

Агуулга

1. Судалгааны үндэслэл.....	2
2. Судалгааны зорилго, зорилт.....	3
3. Судалгааны арга зүй.....	3
3.1. Ойн хөнөөлт шавжийн судалгааны арга зүй.....	3
3.1.1. Ойн хөнөөлт шавж илрүүлэх, цуглуулах арга.....	3
3.2. Ойн зонхилогч хөнөөлт шавжийг тодорхойлох арга зүй.....	5
3.2.1. Монгол орны ойд түгээмэл тархалттай зарим эрвээхэйг бие гүйцсэн бодгалиар тодорхойлох.....	5
3.2.2. Өндгөөр ялгаж таних.....	10
3.2.3. Хүрэнцэрээр ялгаж таних.....	12
3.2.4. Хүүхэлдэйгээр ялгаж таних.....	15
3.3. Ойн хөнөөлт шавжийн популяцийн тархалтыг тогтоох арга.....	17
3.4. Ойн хөнөөлт шавжийн үнэмлэхүй нягтшилтыг тогтоох арга.....	18
3.5. Ойн хөнөөлт шавжийн голомт, тооны хөдлөл зүй, хэт олшролтыг тогтоох арга.....	19
3.5.1. Ойн хөнөөлт шавжийн голомтыг тогтоох.....	19
3.5.2. Хөнөөлт шавжийн тооны хөдлөл зүй, хэт олролтыг тогтоох арга.....	20
3.6. Мониторинг судалгааны арга зүй.....	23
4. Судалгаа явуулсан газар нутаг.....	36
5. Судалгааг гүйцэтгэсэн бүрэлдэхүүн.....	41
6. Судалгааг гүйцэтгэсэн үе шат, хугацаа.....	42
7. Судалгааны ажлын бэлтгэл.....	43
8. Судалгаанд хэрэглэсэн техник, багаж хэрэгсэл, хэрэглэхүүн.....	43
9. Судалгааны үр дүн.....	43
9.1. Ойд хөнөөл учруулж буй шавжийн зүйл.....	43
9.2. Ойн хөнөөлт шавжийн үнэмлэхүй нягтшилт.....	57
9.3. Ойн хөнөөлт шавжийн тархалт, голомт.....	59
9.4. Тэмцлийн ажлын үр дагаврын мониторинг судалгаа.....	66
9.5. Ойн хөнөөлт шавжтай 2018, 2019 онд тэмцэл явуулах талбайн хэмжээ.....	66
Дүгнэлт, санал.....	68
Ашигласан материал.....	69
Хавсралт.....	

1. Судалгааны үндэслэл

Монгол орны ой мод нь ус зохицуулах, хадгалах, цэвэршүүлэх, хөрсийг элэгдэл эвдрэлээс хамгаалах, уур амьсгалыг зөөлрүүлэх, хүлэмжийн хийг шингээх, биологийн төрөл зүйлийн амьдрах таатай орчин болох, мөнх цэвдгийг тогтоон барих зэрэг экологийн өндөр ач холбогдолтой байдгаас гадна нийгэмд зориулагдсан үр ашгийн үндсэн нөөц болдог.

Ой мод нь амжиргааны эх үүсвэр болох, ажлын байр бий болгох, нийгмийн сайн сайхан байдлын хангамжыг бүрдүүлэх, соёлын үнэ цэнэ болох зэрэг нийгмийн өндөр ач холбогдолтой байдаг.

“Ойн судалгаа, хөгжлийн төв” УТҮГ-аас 2014 онд гаргасан ой зохион байгуулалтын ажлын дүн, мэдээнээс харахад 2009 оноос 2014 оны хооронд Монгол орны ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээ 1,126.0 мянган га-гаар багасаж ойгоор бүрхэгдээгүй талбайн хэмжээ 1,294.0 мянган га-гаар нэмэгдэж ойрхог чанар 8,3 хувиас 7,8 хувь болтлоо буурсан бөгөөд 2009-2014 оны хооронд 885,6 мянган га ой түймэрт өртөж, 76,2 мянган ой хөнөөлт шавжид нэрвэгдсэн байна.

Эндээс харахад Монгол орны эмзэг тогтоц бүхий экологи, нийгэм, эдийн засгийн өндөр ач холбогдолтой ойн экосистемид сөрөг нөлөө үзүүлж буй үндсэн хүчин зүйлүүдийн нэг нь ойн хөнөөлт шавж, өвчний хөнөөл юм. Сүүлийн жилүүдэд цаг агаарын өөрчлөлт, хуурайшилт, түймэр, хүний ойд учруулж буй сөрөг үр дагавар, хөнөөлт шавж, өвчний үржин олшрох биологийн зүй тогтол зэрэгтэй холбогдон ойн хөнөөлт шавж, өвчин хэт олширч хөнөөлийн голомтууд үүсгэн байгалийн гамшиг болохуйц хэмжээний хөнөөл учруулж байна.

Манай оронд 600 гаруй зүйлийн ойн хөнөөлт шавж бүртгэгдсэн байдаг. Эдгээрийн дотроос хамгийн түгээмэл тархалттай, цоо эрүүл, үнэт модлог эд бүхий шилмүүст моддод довтлон үхүүлэх хүртэл хөнөөл учруулдагаараа бусад шавжаас эрс ялгарах хайрсан далавчтаны багийн Сибирийн хүр, Өрөөсгөл хүр, Бургасны болон Нарсны хүр, Эгэл бийрэн сүүлт, Якобсоны төөлүүр, Шинэсний шилмүүс эргүүлэгч саарал эрвээхэй зэрэг 20 гаруй зүйлийн тархалтыг тогтоосон /Б.Намхайдорж, И.Дорж, Б.Гэрэл, 2006 /.

Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлыг улсын хэмжээнд баггүй хэмжээний хөрнгө гаргаж, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, “Ойн судалгаа, хөгжлийн төв” УТҮГ “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу тендер зарлан зохион байгуулж, үр дүнтэй гүйцэтгэж байна.

Тэмцлийн ажлыг үр дүнтэй зохион байгуулах, тэмцэл явуулах талбай, аргыг сонгох зорилгоор судалгааны ажлыг зайлшгүй зохион байгуулах шаардлагатай байдаг.

Энэ үүднээс “Ойн судалгаа, хөгжлийн төв” УТҮГ Баянхонгор, Баян-Өлгий, Говь-Алтай, Ховд аймгуудын ойн санд тархсан хөнөөлт шавжийн тархалтыг тогтоох, тэмцлийн ажил явуулах талбайг сонгох судалгааны ажлыг гүйцэтгүүлэхээр зөвлөх үйлчилгээний тендер зарласан.

Тус зөвлөх үйлчилгээ нь манай байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилгод нийцэж байсан тул бид зөвлөх үйлчилгээний санал боловсруулан оролцож, Баянхонгор, Баян-Өлгий, Говь-Алтай, Ховд зэрэг аймагт судалгааны ажил гүйцэтгэхээр болсон.

2. Судалгааны зорилго, зорилт

Тус ажил нь ойн хөнөөлт шавжийн экологи биологийн онцлог, тархалтыг тогтоох, тэмцлийн ажил явуулах талбайг сонгох, тэмцлийн ажлын үр дагаврын

мониторинги хийх зэрэг судалгааг гүйцэтгэж “Ойн судалгаа, хөгжлийн төв” УТҮГ –т зөвлөх үйлчилгээ үзүүлэх зорилготой бөгөөд дараах зорилтуудыг хэрэгжүүлэхээр байсан. Үүнд:

- Судалгаа явуулах газар нутагт хөнөөл учруулж буй голлох ойн хөнөөлт шавжийн зүйлийг тодорхойлох,
- Ойн хөнөөлт шавжийн тархалтын талбайн хэмжээг ой зохион байгуулалтын материал ашиглан аймаг, сумын хэмжээнд гаргах,
- Ойн хөнөөлт шавжийн харьцангуй нягтшилтийг гаргах,
- Ойн голлох хөнөөлт шавжийн биологи, экологийн онцлогийг судлаж фенологийн хүснэгтүүд боловсруулах
- Тэмцлийн ажил гүйцэтгэсний дараа мониторинг судалгааг хийж тэмцлийн ажлын үр дүнг тооцон, хэрэглэж буй бодис, бэлдмэл, арга технологийн шавжийн бүлгэмдэл үзүүлэх сөрөг нөлөөг судалж тогтоох,
- Төрөөс явуулж буй ойн бодлогын талаар ард иргэдээс судалгаа аван, мониторинг хийх,
- 2019, 2020 онд ойн хөнөөлт шавжтай тэмцэл явуулах талбай сонгож, төлөвлөгөөг боловсруулах зэрэг болно.

3.Судалгааны арга зүй

Судалгааг 2010 онд "Байгаль орчин, тогтвортой хөгжлийн санаачлага" ТББ-ын эрдэмтэд судлаачдын баг боловсруулж, ХААИС-ын харъяа Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2011 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцэгдэж батлагдсан арга зүйгээр “Ойн хөнөөлт шавжийн тархалтыг тодорхойлох судалгааны ажилд тавих ерөнхий шаардлага” MNS 6533:2015, “Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлын үр дүнг тооцох ажилд тавих ерөнхий шаардлага” MNS 6533:2015 стандартуудын дагуу гүйцэтгэсэн.

3.1. Ойн хөнөөлт шавжийн судалгааны арга зүй

3.1.1. Ойн хөнөөлт шавж илрүүлэх, цуглуулах арга

Ойн хөнөөлт шавжийг илрүүлж цуглуулахдаа дараах аргуудыг хэрэглэнэ.Үүнд:

Ховойгоор шавж илрүүлж, цуглуулах арга

Энэ арга хамгийн түгээмэл дэлгэрсэн арга юм. Ихэвчлэн бие гүйцсэн шавж, эр эм эрвээхэй, цохыг илрүүлж барихын тулд ургамлан бүрхэвчид 15-20 удаа ховоогоор шүүрдэлт хийнэ.

Мөн энэ аргаар модны навч, шилмүүс, нахиа, үр жимсээр хооллодог шавжийг илрүүлж цуглуулахад хэрэглэж болдог. Ингэхийн тулд ховооны ишийг модны титэмд хүрэхүйц урт хийх хэрэгтэй. Модны титмийн хэсэгт ховоогоор шүүрдэлт хийж илэрсэн шавжийг цуглуулан үхүүлж хадгална.

Модны гол ишийг доргиох, мөчрийг сэгсрэх замаар шавж илрүүлж, цуглуулах арга

Модны титмийн дор 10 м² хэмжээтэй дэлгэц материалыг дэлгэж тавин модыг сэгсэрч, доргион дэлгэц дээр унасан шавжийг цуглуулна.

Энэ аргыг хөнөөлт эрвээхэйн хүрэнцэр, төөлүүр, хүүхэлдэйн шатанд нь илрүүлэхэд өргөн хэрэглэдэг.

Далд байрлах хөнөөлт шавж илрүүлж, цуглуулах

Модны гол иш, мөчир, үр жимс, навчны эдийн дотор амьдардаг шавжийг цуглаалахдаа тэдгээрийг нэг бүрчлэн задалж илэрсэн шавжийг түүж цуглуулна.

Энэ аргыг ихэвчлэн гол ишний хөнөөлт шавжийн авгалдай, хүүхэлдэй, ургамлын бөөсийг илрүүлж цуглуулахад хэрэглэдэг.

Наалдуулагч цагираг хийж шавж илрүүлж, цуглуулах арга

Энэ арга нь модонд наалдуулагч бүслүүр хийж шавж цуглуулах арга юм. Модон дээр амьдарч буй шавжууд модны гол ишийг дагаж тогтмол өгсөж уруудаж байдаг.

Наалдуулагч бүслүүрийг олс, сүрэл, картон цаас, цагираг төмөр зэрэг янз бүрийн материал ашиглан хийж болно.

Энэ аргыг ойн голлох хөнөөлт шавжийн нэг сибирийн хүр эрвээхэйн хүрэнцэрийг илрүүлэхэд өргөн хэрэглэдэг.

Сибирийн хүр эрвээхэйн хүрэнцэр нь намар титмээс гол ишээр дамжин хөрсөнд орж өвөлжөөд хавар хөрснөөс гарч гол ишээр дамжин титэмд байрладаг.

Гэрлээр урхидах арга

Энэ нь янз бүрийн гэрлийг ашиглан шөнийн идэвхтэй шавжийг цуглуулдаг арга юм. Ихэвчлэн ойн хөнөөлт шавжийн бие гүйцсэн эрвээхэйг илрүүлэхэд хэрэглэдэг. Сибирийн хүр, Өрөөсгөл хүр зэрэг хөнөөлт эрвээхэйнүүд гэрлээр хялбархан татагдаж ирдэг.

Хамгийн хялбар гэрлэн урхи бол байшин барилгын гадна зүүж гэрэлтүүлдэг энгийн гэрэл юм.

Гэрлээ цагаан хананы өмнө байрлуулах, эсвэл цагаан даавуун дэлгэцний өмнө байрлуулбал урхинд улам олон шавж цуглардаг.

Хөрсөнд байгаа шавжийг илрүүлж, цуглуулах

Тодорхой хэмжээний эзэлхүүнтэй хөрсний дээжийг хүрз гэх мэт багаж ашиглан дээж болгон авч гараараа бутлан илрэх шавжийг түүж, дараа нь буталсан хөрсийг шигшүүрээр шигшиж илэрсэн шавжийг цуглуулна.

Энэ аргыг хөрсөнд өвөлжсөн Сибирийн хүр эрвээхэй хүрэнцэр, хүүхэлдэйлэхээр хөвхөн давхаргад орсон Якобсоны төөлүүрч эрвээхэйн төөлүүр, мөн хүүхэлдэйг илрүүлэхэд хэрэглэнэ.

Хөрсний дээжийг 0.5метрх0.5метрх0.15метр хэмжээтэйгээр авна.

3.2. Ойн зонхилогч хөнөөлт шавжийг тодорхойлох арга

Ойн инженер, байгаль хамгаалагч, ойн мэргэжилтэн зэрэг орон нутаг ажиллаж байгаа ажилтнууд нь тухайн орон нутгийн ойд үе үе хэт олширч хөнөөл учруулдаг зүйлүүдийг эрвээхэй, өндөг, хүрэнцэр, хүүхэлдэйн шатанд таньж тодорхойлох чадвартай болох шаардлагатай байдаг.

Ингэж чаддаг болсноор ойн хөнөөлт шавжийн талаар үнэн зөв мэдээллийг дээд байгууллагууддаа өгч улмаар судалгаа, тэмцлийн ажлыг шуурхай зохион байгуулахад дөхөм болно.

Энд ойн зонхилох хөнөөлт эрвээхэйг бойжилтын үе шат бие гүйцсэн бодгалиар таньж тодорхойлох аргыг оруулж байна.

3.2.1. Монгол орны ойд түгээмэл тархалттай зарим эрвээхэйг бие гүйцсэн бодгалиар тодорхойлох

1 (6) Бие гүйцсэн эрвээхэй далавчгүй эсвэл үлдэгдэл төдий далавчтай.

2 (5) Бие гүйцсэн эрвээхэйн далавч үлдэгдэл төдий.

3(4) Эрвээхэйн бие 0.7-0.8 см урт. Биеийн өнгө саарал, далавч үлдэгдэл төдий жижиг, биеийнхээ уртын хагаст ч хүрэхгүй. Урд далавчинцарын гадаад захад хоорондоо нийлсэн 2 бараан хөндлөн зураастай. Өвлийн төөлүүрч эрвээхэй (*Oporophthera brumata* L).

Эм эрвээхэй өдрийн цагаар нуугдах орчинд байж, шөнө идэвхитэй хөдөлж амьдарна. Өндгөө 10-11 сард модны холтосны завсарт шахдаг.

4(3) Эрвээхэйн биений урт 1.5 см орчим. Далавчны ор төдий үлдэгдэлтэй. Биеийн өнгө цайвар шаргал, сэвсгэр үс хайрсан бүрхүүлтэй
Эгэл бийр сүүлтийн эм эрвээхэй (*Orgyia antiqua* L).

Эм эрвээхэй 8-9-р сард навчит, шилмүүст мод ялангуяа шинэс модны гол иш, мөчир дээр өндгөө шахдаг.

5(2) Эрвээхэйн бие нь 1.6-1.8 см урт, огт далавчгүй, саарал өнгөтэй. Том ба жижигхэн хар, цагаан толбонуудтай. Хэвлийн төгсгөл урт нарийхан
. Якобсоны эм төөлүүрч (*Erannis jacobsoni* Diak.).

Эм эрвээхэй өндгөө холтосны завсарт далд 2-6 ширхэгээр шахдаг. Мододын гол ишний 2-6 метрийн өндөрт холтосыг хуулж түүний өндгийг олдог.

6(1) Бие гүйцсэн эрвээхэйн далавч сайн хөгжсөн.

7(10) Эр эрвээхэйн дэлгэмэл далавч 2.3-2.8 см урт. Урд далавч цайвар-бор саарал юм уу загал цагаан өнгөтэй.

8(9) Эрвээхэйн дэлгэмэл далавч 2.3-2.7 см-ээс хэтрэхгүй урт. Урд далавч загал-цагаан, саарал өнгийн хэд хэдэн хөндлөн нарийн судалтай- Хойт далавч цагаан. Сахал өд хэлбэртэй Өвлийн эр төөлүүрч эрвээхэй (*Oporophthera brumata* L.)

9(8) Эрвээхэйн дэлгэмэл далавч 2.5-2.8 см урт. Урд далавч цайвар-бор өнгөтэй, тод бор хөндлөн судлуудтай. Биеийн өнгө боровтор. Далавчны захаар урт, шигүү цацагтай. Хойд далавч цагаан. Сахал өд хэлбэртэй
.Якобсоны төөлүүрч эр эрвээхэй (*Erannis jacobsoni* Diak).

Эр эрвээхэй орой бүрийд ниснэ. 10-11 сард зонхилж идэвхитэй нисдэг.

10(7) Эрвээхэй өөр өнгөтэй. Биеэр том.

11(14) Эр, эм эрвээхэй адилхан цагаан өнгөтэй, заримдаа төдий л тод бус хээ, бараан зурааснуудтай.

12(13) Бие, далавчнууд цагаан, судаснууд хар. Сууж буй эрвээхэй далавчаа биен дээрээ эгц босоо байрлуулна. Дэлгэмэл далавч нь 6 см урт
Долоогоны цагаан эрвээхэй (*Aporia crataegi* L.)

13(12) Далавч, бие дун цагаан, маш нягт сэгсгэр үс хайрсан бүрхүүлтэй. Дэлгэмэл далавчны урт 4-5 см. Хөлнүүд цагаан, хар цагирагтай
.Бургасны цагаан хүр (*Leucoma salicis* L).

Бургас бүхий ой, бургасан шугуйд 6-7 сард ихэвчлэн сартай шөнө ниснэ. Өдөр модны гол ишин дээр хөдөлгөөнгүй суух дуртай.

14(11) Эр, эм эрвээхэй өөр өнгө зүстэй ба хойт урд далавчнууд ялгаатай өнгө зүстэй. Эрийн далавч 5 см урт, бор-шаргал зүстэй. Эм эрвээхэй цагаан далавчтай, олон хар зураастай.

15(16) Эр эрвээхэй бор-шаргал 3.5 см урт далавчтай, хөндлөн чиглэлийн 4 шүдэжсэн бараан судалтай, жижиг бараан толбонуудтай. Хойт далавч боровтор. Сахал өд хэлбэртэйӨрөөсгөл эр хүр эрвээхэй (*Ocneria dispar*L.)

7-8 сард өдрийн цагт мододын орой хавиар эргэлдэж нисэх дуртай.

16(15) Эм эрвээхэй цагаан өнгөтэй. Бие том, хэвлий бүдүүн. Олон тооны тахир хар зурааснуудтай. Сахал учиг хэлбэртэй.Эм Өрөөсгөл хүр эрвээхэй (*Ocneria dispar* L).

7-9 сард өдрийн ба шөнийн цагаар ниснэ. Гэрэлд нэн олноороо нисэж ирдэг.

17(23) Эрвээхэйн бие том, дэлгэмэл далавч 6 см-ээс доошгүй урт, хар, бор-саарал өнгийн, заримдаа од бүхий далавчтай.

18(19) Эрвээхэйн дэлгэмэл далавч 5.8-6 см урт, хар-бор өнгөтэй, захаараа цайвар-шаргал хамжаартай, түүн дээрээ тасархайтсан эгнээ бүхий жижигхэн цэнхэр толбуудтай Гунигийн эрвээхэй (*Vanessa antiopa* L).

Энэ эрвээхэй намрын эх, зуны сүүлээр гол горхины хөвөө, нуга, шавар, шавхай бүхий орчинд нисэж амьдарна.

19(18) Эрвээхэйн бие том, дэлгэмэл далавчны нийлсэн урт 7 см-ээс багагүй.

20(24) Далавчнууд дээрээ од сар хэлбэрийн болон, өөр хэлбэрийн том толбонуудтай.

21(22) Эрвээхэйн дэлгэмэл далавч 7 см урт. Урд далавчны гадаад захад ухлаадастай. Боровтор өнгөтэй боловч ягаан туяатай. Толбо, хээ хуаруудтай. Хойд далавч урдахаасаа үзэгдэхүйц жижиг, цайвар ягаан өнгөтэй, булан хавьдаа ганц том, бараан дугираг толботой, түүнийхээ дотор цэнхэр цагирагтай.Одот шумбуур (*Smerinthus ocellatus* L).

Эрвээхэй хаврын сүүлч, зуны эхэн үеэр ниснэ. Улиас, улиангар, бургасан ой шугуйд тохиолдоно. Ихэвчлэн шөнө ниснэ. Гэрэлд нисэж ирдэг.

22(21) Далавчны дэлгэмэл урт 7-7.5 см. Цайвар-бор боловч саарал хольц бүхий зүстэй. Далавчин дээрээ нүдлэг том толботой, бараан хөндлөн судлуудтай захаараа арай цайвар өнгөтэй. Эр эрвээхэйн хойт далавч шаргал. Бага тогосон одот эрвээхэй (*Saturna pavonia* L).

Элдэв бут сөөг бүхий орчинд тохиолдоно. Эрвээхэй 6-7 сард нисэх бөгөөд, шөнө гэрэлд нисэж ирдэг.

23(17) Эр эрвээхэй биеэр жижиг. Дэлгэмэл далавчны урт 3 см-ээс хэтрэхгүй. Далавчны дээд гадаргуу зэвэрхүү боровтор өнгөтэй. Урд далавчин дээр тод бус 2 судалтай. Далавчны хойд буланд хагас сар хэлбэрийн цагаан толботой Бийр сүүлт эр эрвээхэй (*Orgyia antiqua* L).

Эр эрвээхэй зуны сүүлчээр шилмүүст болон холимог ойд идэвхитэй нисдэг.

24(20) Далавчин дээрээ од, сар хэлбэрийн толбогүй.

25(28) Эрвээхэйн дэлгэмэл далавчны урт 9 см-ээс дутуугүй. Далавч бор-шаргал, хар-бор холимог саарал өнгөтэй.

26(27) Эрвээхэйн дэлгэмэл далавч 9 см хүрнэ. Урд далавчны өнгө бор, бор-шаргал, эсвэл бүдэг саарал. Далавчин дээрээ 3 хөндлөн зураастай. Хааяа улбар бор бүслүүртэй. Далавчны хойд зах хавьд хагас сар хэлбэрийн жижиг толбо (заримдаа) үзэгдэнэ. Хойт далавч боровтор өнгөтэй Нарсны хүр эрвээхэй (*Dendrolimus pini* L).

Эрвээхэй оройн бүрий, шөнө ниснэ. Нарсан ой ялангуяа 15-30 насны зулзаган ойд 6-7 сард олноороо тохиолдоно.

27(26) Эрвээхэйн өнгө зүс, биеийн хэмжээ дээрхи зүйлтэй их төстэй. Ихэвчлэн урд далавч хар-бор холимог саарал өнгөтэй. Далавчны захад хөндлөн зураастай, тэр хавьдаа жигд бус цайвар хөндлөн судалтай. Хойт далавч боровтор-саарал зүстэй, тод бус хос бараан бүслүүртэй. Сибирийн хүр (*Dendrolimus superans* Tschetv).

Эрвээхэй 6-8 сард ниснэ. Шинэс, хуш, гацууран ой болон холимог ойд нэн элбэг тохиолдоно.

28(25) Дэлгэмэл далавчны урт 9 см-ээс хэтрэхгүй.

29(32) Урд далавчны дэлгэмэл урт нь далавчны үнэмлэхүй өргөний 2 дахинд хүрэхгүй.

30(31) Эрвээхэйн дэлгэмэл далавчны урт 4 см. Эр эрвээхэйн далавчны зах хар бор, дундаа цайвар толботой. Хойт далавчны цайвар хэсгийг бараан бүслүүр дайран өнгөрнө. Эм эрвээхэйн далавчны дээд өнгө шаргалдуу, доод гадаргуу мөнгөлөг цагаан боловч бараан зурааснуудтай. Модон дээр суухдаа далавчаа

хом хэлбэрээр эвхэн байрлуулна. Нарсны төөлүүр
(*Bupalus pinarius* L).

Эрвээхэй 5-7 сард нарсан болон шилмүүст ойд идэвхитэй ниснэ.

31(30) Эрвээхэйн дэлгэмэл далавч 2.5-3.0 см орчим урт, урд далавч цайвар-бор өнгөтэй. Түүн дээрээ хөндлөн тод бор 4 судалтай. Хойд далавч судалгүй, үл мэдэг цайвар өнгөтэй. Хойд захдаа цацагтай. Сахал нарийн өд хэлбэртэй
. Якобосны эр төөлүүр эрвээхэй (*Erannis jacobsoni* Diak.).

Шинэс модон дээр болон холимог ойд зонхилж тохиолдоно. 8-9 сард илүү идэвхитэй нисдэг.

32(29) Урд далавчны дэлгэмэл урт 2.2 см. Үнэмлэхүй өргөнийхөө 2 дахинаас илүү урт. Бие жижигхэн.

33(34) Урд далавч саарал, бараан өнгийн хос бүслүүртэй, үзүүр хэсэгтээ хувирамтгай хэлбэр бүхий толботой. Хойд далавч боровтор үзүүртээ илүү бараан. Уруулын тэмтрүүлүүд богино, шулуухан. Шинэсний шилмүүс эргүүлэгч саарал эрвээхэй (*Zeirophera semiasia dimana* Germ.).

Эрвээхэй 7-8 сард холимог, навчит, шинэсэн ойд ниснэ.

34(33) Дэлгэмэл далавч 1.6-2.5 см урт. Эм эрвээхэйн далавч бор-шаргал, үзүүр хэсэг үл мэдэг нугарсан, хөндлөн бараан зураастай, тод бус ташуу бүслүүртэй. Хойт далавч бор саарал үзүүрлүүгээ бор-шаргал өнгөтэй. Урд далавч улбар-бор, уг хэсэгтээ бүдэг саарал толботой, дундаа бор-шаргал ташуу бүслүүртэй. Уруулын тэмтрүүлүүд урт, тахир. Нарсны шилмүүс эргүүлэгч (*Archips piceana* L).

Эрвээхэй шилмүүст ойд 6-7 сард нисдэг.

3.2.2. Өндгөөр ялгаж таних арга

Сибирийн х□р эрвээхэй - Dendrolimus superans sibiricus
Tschetv

Эмэгчин эрвээхэй өндгөө ихэвчлэн шинэс, нарс, хуш, гацуур, жодоо модны мөчир, гишүү, шилмүүс дээр хааяа гол ишний холтосон дээр шахна. Өндөг нь харьцангуй өргөн гонзгойвтор зууван хэлбэртэй бөгөөд хамгийн өргөн хэсэгтээ 2.2 мм хүрнэ. Уртаашаа 2.4-2.5 мм байдаг. Дөнгөж шахагдсан өндөг хөхөвтөр-ногоон өнгөтэй, хальсан дээрээ 1 ширхэг бараан цэгтэй байснаа

яваандаа саарал өнгөтэй болдог. Ийм үедээ нарсны хүр эрвээхэйтэй андуурагдахаар харагдах боловч арай бараавтар байдаг.

Нарсны хөр эрвээхэй - Dendrolimus pini L.

Эмэгчин эрвээхэй өндгөө зонхилж нарсны мөчир, гишүү, шилмүүс дээр шахах боловч хааяа шинэс, хуш, гацуурын шилмүүс дээр шахна. Өндөгнөөс дөнгөж буй болсон хүрэнцэр тэдгээр модны шилмүүсээр хооллоно. Өндөг нь 2.5 - 2 x 1.8 мм хэмжээтэй гонзгойдуу бөөрөнхий хэлбэртэй. Дөнгөж шахсан өндөг цэнхэрдүү-ногоон, орой хавьдаа бараан цэгтэй. Нэг багцанд 10-100 ширхэг өндөг байна. Зөв бус байрлалтай.

Нарсны түүлөр эрвээхэй - Bupalus piniastrius L

Өндөг нь маанийн эрх маягаар цуварсан байх боловч хэвтээ байрлалтай байдаг. Заримдаа ганц нэгээр шахах тохиолдол буй. Нарсны шилмүүсний ард буюу сүүдэр талд хааяа, ихэвчлэн шилмүүсний гилгэр гадарга дээр хажуу талаараа бэхлэгдсэн байдаг. Хавтгай буюу бага зэрэг дарагдсан юм шиг харагдана. Өндөг 1-1.2 x 0.5 x 0.25 мм хэмжээтэй. Үл мэдэг гялгар, гадарга нь зөөлөн, цаймар-ногоон сүүлдээ шар ногоон болж хувирна. Хүрэнцэр болохын өмнө бүр шил шиг тунгалаг болдог. Нэг эрхилэг цуваанд 10-15 өндөг байдаг. Өндгөө 6 сард шахна.

Буйр сөлм эрвээхэй - Orgyia antiqua L

Өндгөө хонгионд шахна. Өндөг 0.75 x 0.8 мм хэмжээтэй буюу бараг бөмбөлөг хэлбэртэй, бүрзгэр цагаан өнгөтэй орой хавьдаа бараан толботой, түүний ойролцоо бүслүүртэй. Нэг хонгионд хэдэн 10-аас 100 орчим өндгөө бургас, хус, улиас) болон шинэсэн ойн шилмүүс дээр шахна. Хэт олноороо үржих үедээ нэг модон дээр маш олон өндөг шахна.

Долоогоны цагаан эрвээхэй –Aporia crataegi L.

Өндөг лийр хэлбэртэй 12-14 тууш, тод хянгатай, тэдгээр нь өндөгний суурьд хүрэхгүй. Суурь хэсэг гилгэр алтлаг-шар өнгөтэй 1.5 x 0.8 мм хэмжээтэй. Модны навчны дээд, доод гадарга дээр 50 -200 ширхэгээр шахна.

Сүл хөр эрвээхэй - Osneria dispar L.

Шахагдсан багц өндөг саарал ба бор-шаргал үслэг, жинтүү маягийн зууван ба уртавтар-өндөг хэлбэртэй, 4 см орчим урт, өргөн нь 2 см орчим байдаг. Хадны ангал, модны холтосны завсар мэтийн нуугдмал орчин болон шууд холтосон дээр, байшингийн ханан дээр ч шахаад эмэгчин эрвээхэй хэвлийнхээ үсээр хучиж орхидог. Өндгөө навчит ба шилмүүст модон дээр шахна. Нэг өндөг 1.4 x 1.0 хэмжээтэй, бөмбөлөг буюу 2 үзүүр талаас үл мэдэг шахагдсан, торх хэлбэртэй. Дөнгөж шахагдсан өндөг улаан-шаргал өнгөтэй яваандаа шарлаад эцэст нь саарал болж хувирна. Өндөгний хальс үрчгэр бөгөөд маш нарийн шивээнүүдтэй.

Шинэсч саарал эрвээхэй - *Semiasia diniana* Gn.

Эм эрвээхэй өндгөө жижигхэн багц байдлаар шинэс модны холтосны долорхойн завсарт болон гол ишин дээр ургасан хаган доор шахна. Хааяа өөр шилмүүст модон дээр шахсан байдаг. Өндөг өвөлжинө. Өндөг зуувандуу хавтгай хэлбэртэй. Өсгөгч дурангаар харвал дээд тал нь бэржгэр гадаргатай. Дөнгөж шахагдсан өндөг шар туяатай ногоон, сүүлдээ улбар шар, 0.7 x 0.5 мм хэмжээтэй.

Өвлийн төөлүүрч - *Operophtera brumata* L.

Эм эрвээхэй өндгөө янз бүрийн мод бутны холтосны зай завсар, хаг хөвдөн доор, мөчир гишүүний хугархайн зай завсар зэрэг нууцлагдмал орчинд модны дундаас дээш хэсэгт шахна. Өндгөө ганц нэгээр ба цөөн багцаар шахна. Өндөгний бүрхүүл хатуувтар. Өндөг өвөлждөг. Өндөг бөмбөлөг хэлбэртэй, суур хэсэгтээ үл мэдэг нарийссан 0.7 x 0.35 мм хэмжээтэй. Эхний үедээ цэнхэрдүү буюу шар-ногоон, яваандаа улбар, эцэстээ бараа өнгөтэй болно.

Якобсоны төөлүүрч эрвээхэй – *Erannis jacobsoni* Diak.

Эм эрвээхэй өндгөө холтосны завсарт 2-6 ширхэгээр далд шахна. Дөнгөж шахагдсан өндөг тод ягаан-шаргал өнгөтэй 2-3 хоноод цайвар-шар өнгөнд хувирна. Зуувандуу хэлбэртэй гадаргуу дээрээ торлог зурааснуудтай. Өндөгний урт 1.0 мм өргөн нь 0.45-0.5 мм орчим хэмжээтэй.

3.2.3. Хүрэнцэрээр ялгаж таних арга

Шинэсний саарал эрвээхэй - *Zeiraphera (Semiasia) diniana* Gn.

Энэ зүйл нь навч эргүүлэгчдийн овогт (Tortricidae) багтана. Хүрэнцэр 8-12 мм урт, ногоовтор-саарал, 3 ширхэг хар-ногоон судлуудтай, тэдгээрийн нэг

зоонд, 2 судал биеийн хажуугаар байрлана. Толгой, дагзны хавтан хар өнгөтэй. Хүрэнцэр нэг жилд бойжиж гүйцнэ. Хүрэнцэрүүд шинэс, хуш, нарс, хааяа гацуур дээр хооллоно. Хүрэнцэрийн хэвлийн төгсгөл дээр 6-8 богинохон шүдэнцэр ба 8 ширхэг дэгээ хэлбэрт шивээтэйгээс 6 нь цагирагийн оройд байрлана. Хүрэнцэр зуны эхэн сард буй болно. Хүрэнцэрийн хооллосон модны мөчир, шилмүүсний үзүүр дээр торлогжуу гэр бий болдог, 4 дахин гуужиж холтосны завсарт орж хүүхэлдэйлнэ.

Шинэсний шилмүүсч эрвээхэй- *Spilonota laricana* Hem.

Хүрэнцэр шилмүүст модон дээр хооллоно. Хүрэнцэрийн урт 10 мм орчим, хүрэн-улаан биетэй байх боловч заримдаа бор-саарал өнгөтэй, хар, хар-бор толгойтой ба дагзны хавтантай. Залуу хүрэнцэр 6 сарын эхнээс бий болно. Тэр үедээ 6-8 шилмүүсийг хооронд нь холбосон үүрэнд байж хооллоно. Өвөлжихдөө нарийн мөчрийг болон найлзуурыг нягт тороор торлон байрлана. Хаврын сүүлч зуны эхэнд найлзуур, шилмүүсээр хооллоно. Бас шошгой идэх явдал буй.

Сибирийн х□р эрвээхэй - *Dendrolimus superans sibiricus* Tschetv.

Хүрэнцэрийн өнгө, зүс нарсны хүрийн хүрэнцэртэй их төсөөтэй. Бор-саарлаас бараан-хүрэн байдаг. Зоон тал ихэвчлэн мөнгөлөг цагаан ба бараан цэгүүдээс тогтсон хээтэй. Тэдгээр нь **цагираг** бүр дээр жигд бус дугуйдуу дүрс үүсгэнэ. Хүрэнцэр шинэс, жодоо, хуш, зэрэг модны шилмүүсээр хооллоно. Хүрэнцэрийн толгой бараан-хүрэн өнгөтэй, бөөрөнхий, өтгөн үсэн бүрхүүлтэй. Түүний үс маш хортой тул хүний нүдэнд орвол сохрох хүртэл аюулд хүргэдэг. Хэт олширсон үедээ нэг модон дээр хэдэн мянгаараа байрлана. Нэг хүрэнцэр 5-6 удаа бойжино. Энэ эрвээхэй Оросын Холбооны Улсаас үе үе манай оронд нэвтрэн орж ирдэг. Хүрэнцэр 1-2 удаа ойн ул хөрсний хэсэгт өвөлжинө. Хөвсгөл, Хангай, Хэнтийн уулархаг бүс нутагт тархан оршино.

Нарсны хүр - *Dendrolimus pini* L.

Хүрэнцэр толгойнхоо дагзны хэсэгт нэг хос хөндлөн толботой. Биеийн урт 9 см хүрнэ. Бор-саарал, саарал, мөнгөлөг-зүстэй, 2,3-р цагираг дээрээ тус бүр нэг ширхэг хар-хөх өнгийн хөндлөн судалтай. Тэр судал нь гялгар өнгийн үснээс тогтдог. Биеийн 4-р цагирагаас эхлэн морины тах хэлбэрийн бараан толботой. Тэр дүрсүүд бие бие рүүгээ харсан байдаг. Хүрэнцэр зонхилж нарсны шилмүүсээр хооллоно. Орчны нөхцөл, идэш тэжээлийн хүрэлцээнээс хамаарч жилд нэг, эсвэл хоёр жилд нэг удаа бойждог. Хүрэнцэр ойн ул хөрс, хөвдөнд өвөлжинө.

Бийр сүүлт эрвээхэй - *Orgyia antiqua* L.

Хүрэнцэрийн хэвлийн 4-7-р цагирагны зоонд 4 согсоотой. Биеийн урт 4 см. Дээр дурьдсан 4 согсоо нь шаргал юмуу бор-үснүүдээс бүрдэнэ. Хэвлийн ар төгсгөлийн 2-р цагираг дээр хар өнгийн сормууслаг бийр байрлана. 2, 4, 5-р цагираг дээрээ хос сормууслаг бийртэй. Хүрэнцэр олон янзын навчит моддын навч, нахиагаар хооллохоос гадна шинэсний шилмүүсийг зарим үед цөлмөн иднэ. Хэт олширсон үедээ гацуур нарсны шилмүүсээр хооллоно. Монгол орны Хан-Хөхий, Хөвсгөл, Хангай, Бүрэн, Бүтээл, Хэнтийн уулархаг бүс нутгийн уул, нуруудад олноороо үржинэ.

Долоогоны цагаан эрвээхэй - *Aporia crataegi* L.

Хүрэнцэрийн бие 4.5 см, өөхийн талдаа цайвар-саарал, хааяа хөхөвтөр туяатай, зоондоо 2 бор-шаргал юмуу ягаавтар, тасархайтсан 3 тууш хар судалтай. Тэдгээр хар судлуудын голынх зооны дунд байрлана. Толгойнд хар цэгүүдтэй. Хүрэнцэр янз бүрийн жимс, жимсгэний мод, бут, сөөгний навчаар хооллон мэдэгдэхүйц хөнөөл учруулна. 6 сарын дунд үеэс 8 сарын 20 хүртэл хооллоно.

Өрөөсгөл хүр эрвээхэй - *Ocneria dispar* L.

Хүрэнцэр саарал өнгөтэй, 5-7 см урт, маш үсэрхэг. Биеийн эхний 5 цагирагны зоон талд гүн хөх өнгийн хос товруутай. Бусад цагираг дээр улаан өнгийн товруутай байдгаас гадна биеийн хажуу талд харьцангуй жижигхэн, үсэрхэг нугачаатай. Биеийн үсэн бүрхүүл хугарамтгай, хорт шүүрэл ялгаруулах тул шавж идэшт шувууд түүнийг идэх нь ховор. Хүний арьсанд хүрвэл хүчтэй хорсгоно. Хүрэнцэр монос, долоогоно мэтийн жимс жимсгэний мод, бут, сөөг төдийгүй гол, мөрөн, горхины бургасан шугуйд олноороо үржиж, навч нахиаг идэж их хөнөөл учруулна. Хүрэнцэр 5 сарын сүүлчээс 6 сард маш идэвхитэй хооллоно. 7 сарын сүүлчээр хүүхэлдэйд шилжиж мөн сарын сүүлч, 8 сард эрвээхэй хаа сайгүй ниснэ. Хэт өссөн үедээ шинэс болон бусад шилмүүст модонд довтлон хөнөөл учруулна. Оросын Холбооны Улсад хэт өссөн үедээ манай умард нутагт нүүдэллэн орж ирнэ Манай орны ойт хээрийн умарт хэсэг ялангуяа Бүрэн, Бүтээл, Хан Хөхий, Хэнтий, Хангай, Тарвагатай, Хөвсгөлийн нутагт өргөн тархдаг.

Нарсны төөлүүр эрвээхэй - *Bupalus piniastrius* L.

Хүрэнцэр үсэн бүрхүүлгүй буюу нүцгэн, ногоон зүстэй. Биен дээрээ 5 тууш байрлал бүхий шаргалдуу-цагаан судалтай. Тэдгээрийн нэг нь голоор, бусад 2 хос биеийн хажуу талд байдаг. Хамгийн доор байрлах судлууд толгойд

хүрнэ. Толгой нь хавтгар. Энэ хүрэнцэр модны мөчир гишүү, шилмүүс дээр төөлж байгаа юм шиг хөдөлдөг. Бойжилт гүйцсэн хүрэнцэр 30 мм орчим урт биетэй. Бусад хөнөөлт эрвээхэй 8 хос хөлтэй байдаг бол төөлүүрчийнх 5 хос хөлтэй байдгаараа онцлог. Хүрэнцэр 6 сарын сүүлчээс 7 сард идэвхитэй хооллоно. Ихэвчлэн шилмүүсний хавтгайдуу гадаргуун талаас мэргж иднэ. Хүрэнцэр намрын дунд сар хүртэл амьдарна. Хүрэнцэр бойжиж гүйцээд ойн ул хөрсөнд шилжин байршиж хүүхэлдэйлнэ. Зонхилон нарсны шилмүүсээр хооллох боловч хааяа гацуур, жодооны шилмүүсийг ч иддэг. Манай орны нарсан ой бүхий бүх нутагт тархдаг.


Өвлийн төөлүүр эрвээхэй - *Operophtera brumata* L.

Өвлийн төөлүүрчийн хүрэнцэр бусад эрвээхэйн **хүрэнцэрээс** эрс ялгагдах онцлогтой. Хүрэнцэр явахдаа цээжний хөлөөрөө ургамлаас зууралдаад их биеийнхээ голоор гогцоо үүсгэн төөлөх маягаар бөгсний хэсгээ татаж явдаг. Хүрэнцэр 5 хос хөлтэй. Цээжний 3 хос, хэвлийн төгсгөлийн 2 хос хөлтэй. Хүрэнцэр шар-ногоон зүстэй, зоондоо тууш байрлалын бараан зураастай, хажуугаараа 3 тууш цагаан судалтай. Бие 3 см орчим урт. Хавар эрт өндөгнөөс эхний хүрэнцэр бий болно. Төдөлгүй цэцгийн дэлбээ, навч, нахиагаар хооллож байгаад навчны ирмэгүүдийг ялман утсаар холбож нэхээд түүндээ орж нуугдана. Түүний хооллолт нэг сар орчим үргэлжилнэ. Үүний дараа модны гол ишний уг хавийн хөрсөнд 3-13 см -ийн гүнд шурган орж хүүхэлдэйд шилжинэ. Намар орой болсон хойно хүүхэлдэйнээс бие гүйцсэн эрвээхэйд шилжинэ. Энэ эрвээхэйн эмийн далавч хөгжөөгүй учир модонд мөлхөн гарч мөчир гишүүн дээр өндгөө шахна.

Якобсоны төөлүүрч эрвээхэй- *Erannis jacobsoni* Diak.

Бойжилтын нэгдүгээр үедээ байгаа хүрэнцэрийн толгой шар өнгөтэй, жижигхэн хар толбонцоруудтай. Биеийнхээ зоонд тууш байрлалын шар-ногоон, голдоо тасархайтсан, хос шар судалтай. Хажуу талдаа цагаан шаргал судалтай. Цээж болон хэвлийн, хөлнүүд цайвар-шар. Бойжилтын хоёр дахь үедээ толгой нь шар өнгөтэй, цайвар-хүрэн цэгүүдтэй, дагзандаа хар зураастай болж улмаар их бие дээрээ цөөн тооны бараан хүрэн шивээнүүдтэй болдог. Хүрэнцэр 4-5 удаа гуужсаны эцэст хүүхэлдэйд шилждэг.

3.2.4. Хүүхэлдэйгээр ялгаж таних арга



Эрвээхэйн хүүхэлдэйн бие бүтэц

1- өөхийн талаасаа, 2-зоон талаасаа Д-дух, З-зулаа, Н-нүд, Ха-хацар, Д.у-доод уруул, С-сахал, Ху-хушуу, У.х.с-урд хөлийн сарвуу, У.д-урд далавч, Х.ц-хэвлийн цагираг, Э.с.-эвслийн сүв, Х.с-хойд сүв, Кр-кремастер, Кр.д-кремастерийн дайвар

Шинэсний саарал эрвээхэй - *Zeiraphera (Semiasia) diniana*Gn.

Хүүхэлдэй 8 см орчим урт, хүрэн өнгөтэй, гялгардуу хэвлийн цагирагууд зоондоо хөндлөн байрлалын өргөснүүдтэй. Далавч нь хаалтуур хэвлийн 4-р цагирагт хүрнэ. Хэвлийн төгсгөл, зоон талд 9-11 шүдэнцэр ба дэгээ хэлбэрийн шивээнүүдтэй. Хүүхэлдэй 7 сарын сүүлч 8 сарын эхээр шинэсэн ойн ул хөрсөнд эсвэл модны холтосны ан цав, гол ишний ёзоор хавьд байрлана.

Сибирийн хүр эрвээхэй- *Dendrolimus superans sibiricu*Tschetv.

Хүүхэлдэйн хонгио пергамент цаасархуу харагдана. Хүүхэлдэйн дүр төрх нарсны хүрийн хүүхэлдэйтэй төстэй харьцангуй том буюу 5-7 см орчим урт. Хүүхэлдэй бараан бор эсвэл хар өнгөтэй. Хүүхэлдэй 6-7-р сард тааралдаж болно. Зонхилж шинэс, хуш, жодоо, хааяа бусад шилмүүст модон дээр байрлана.

Бийр сүүлт эрвээхэй - *Orgyia antique* L

Хүүхэлдэйн бие 1.5 см орчим гялгар, хүрэн зүстэй, өтгөн бус богино шаргал үсэн бүрхүүлтэй. Үсэн бүрхүүл багавтар багц үүсгэнэ. Түүний кремастер нь домборхуу дүрстэй, богинохон дэгээлэг шивээгээр хучигдсан. Хүүхэлдэйн хонгио сэвсгэрдүү бүтэцтэй. Түүнийг хүрэнцэрийн үсэн бүрхүүлээр хийдэг. Хүүхэлдэйн хонгио 2 см орчим урт. Хүүхэлдэй байгалийн янз бүрийн орчин нөхцөлд харилцан адилгүй хугацаанд тааралдах бөгөөд ихэвчлэн 7-9-р сард тохиолдоно. Шинэс модон дээр зонхилж байх боловч заримдаа бусад шилмүүст модны гол иш, титэм дээр тохиолдоно.

Нарсны хүр эрвээхэй - *Dendrolimus pini* L.

Хүүхэлдэйн бие 2.5-4.5 см орчим урт, бүдүүн, хар-бор эсвэл хүрэн зүстэй, бүрзгэр боловч хэвлийн хэсэг үл мэдэг гялгар өнгөтэй. Далавчны хаалтуур хэвлийн 4-р цагирагийн ар ирмэгт арай хүрэхгүй. Хэвлийн төгсгөл жижигхэн дэгээлэг өргөс шивээгээр хучигдсан. Хүүхэлдэйн хуруувчийн урт 3-5.5 см орчим урт, цайвар-саарал, бүдүүн бахим яламаас бүрдсэн байдаг. Хүүхэлдэй 6-7 сард гол иш титэм дээр тохиолдоно. Хуучин хуруувч бүх л зуны туршид тохиолдоно.

Өрөөсгөл хүр эрвээхэй - *Oscneria dispar* L.

Хүүхэлдэй 2-3.8 см орчим урт, хар-бор, бүрзгэр шаргалдуу үснүүдтэй. Кремастер харьцангуй урт, үрчлээстэй шулуун хэлбэртэй бөгөөд үзүүртээ дэгээ хэлбэрийн олон өргөстэй. Тэдгээрээс 2-3 ширхэг нь бусдаасаа урт байдаг. Хүүхэлдэйн хэвлийн цагирагуудын урд хэсэг хөндлөн чиглэлийн зурааснуудтай. Хүүхэлдэй 6-7 сард яламлаг хуруувчиндаа байх бөгөөд үсэн бүрхүүлгүй нүцгэн. Хүрэнцэрт идэгдэж гэмтсэн, хатсан навчис болон гол ишин дээр, бас мөчир гишүүн дээр тохиолдоно.

Долоогоны цагаан эрвээхэй-*Aporia crataegi* L.

Биеийн урт 2.5 см, шаргал эсвэл шар-ногоон өнгөтэй, гадаргуу дээрээ хар толбонуудтай. Толгой дээрээ товгортой, голоороо тууш шантай. Цээжний зоонд тууш хянгатай. Хэвлийн өөхийд тууш өргөн хар судалтай. Кремастер нь зоо өөхийн талаасаа хавтгар, хянгалаг дүрстэй, жижигхэн дэгээнүүд үзүүрт байрлана. Хүүхэлдэй 5-6 сард ихэвчлэн жимс, жимсгэний мод, бутны титмийн мөчир дээр тусгай ялман бүслүүрээр бэхлэгдсэн байдаг.

Нарсны төөлүүрч эрвээхэй-*Bupalus piniarius* L.

Хүүхэлдэйн бие 0.7-1.5 см урт, гялгар бор өнгөтэй бөгөөд үл мэдэг ногоондуу туяатай. Кремастер үрчлээтсэн, оройдоо богино конус хэлбэрийн өргөстэй. Хүүхэлдэй өвөлжинө.

Өвлийн төөлүүр-Operophtera brumata L.

Хүүхэлдэй цайвар бор өнгөтэй, хэвлийн төгсгөл хэсэг дээрээ I-хэлбэрийн өргөстэй. Биеийн урт 5-8 мм. Биеийн боожилт нэг жилд гүйцнэ. Бойжилт гүйцсэн хүрэнцэр 5-6 сарын сүүлчээр хөрсөнд орж хүүхэлдэйд шилжинэ. Иймд хүүхэлдэйг олохын тулд хөрсний өнгөн хэсэгт /модны гол ишний ёзоор хавьд/ ухалт хийж хайх шаардлагатай. Хүүхэлдэй хөрсөнд намар болтол байрлана. Энэ зүйлтэй тэмцэх ажлыг зохион байгуулах хамгийн шилдэг арга бол модны гол ишин дээр наалдуулагч бүслүүр тавих ажил болно.

Якобсоны төөлүүрч эрвээхэй-Erannis jakobsoni Diak.

Бойжилтоо гүйцээсэн хүрэнцэр модны гол ишээр дамжин уруудаж хөрсний өнгөн хэсэг буюу хагдарсан өвсний доор шурган орж хүүхэлдэйлнэ. Хүүхэлдэйн бойжилт 2 сар шахам үргэлжилдэг. Биеийн өнгө цайвар хүрэн 2-2.5 см урт, биеийн гадуур тусгай хонгиогүй буюу нүцгэн байдаг.

3.3. Ойн хөнөөлт шавжийн популяцийн тархалтыг тогтоох арга

Ойн хөнөөлт шавжийн тохиолдох газар нутгийн хүрээг тухайн зүйлийн тархалт гэж үзнэ.

Ойн хөнөөлт шавжийн тархалтыг орчны температур, чийг, махчин, шимэгч гэх мэт маш олон хүчин зүйл хязгаарлаж байдаг.

Ойн хөнөөлт шавжийн популяцийн тархалтыг орон нутгийн хэмжээнд болон бүс нутгийн хэмжээнд гаргадаг.

Ойн хөнөөлт шавжийн тархалтыг тогтоохдоо хээрийн судалгааны явцад ойн хөнөөлт шавж илэрсэн хэсэглэл, ялгарлын дугаар, газарзүйн солбицолыг ой зохион байгуулалтын план зураг, таксацийн бичиглэлийг ашиглан тэмдэглэж тэмдэглэсэн хэсэглэл, ялгарлын дугаар, газарзүйн солбицолыг газарзүйн мэдээллийн системд оруулан гаргана.

Монгол орны ойн сан бүхэлдээ газарзүйн мэдээллийн системд холбогдсон байдаг.

3.4. Ойн хөнөөлт шавжийн үнэмлэхүй нягтшилтыг тогтоох арга

Ойн хөнөөлт шавжийн үнэмлэхүй нягтшилт гэж нэгж талбайд эсвэл нэг модонд байгаа шавжийн тоог хэлнэ.

Ойн хөнөөлт шавжийн нягтшилтыг тооцох нь хөнөөлт шавжийн голомтыг илрүүлэх, тэмцлийн ажлын үр дүнг тооцох зэрэгт чухал ач холбогдолтой байдаг.

Ойн хөнөөлт шавжийн нягтшилтыг дараах аргаар тооцно.

Доргиох арга

Ойн хөнөөлт шавжийн хүрэнцэр, хүүхэлдэй төөлүүрийн шатанд нь доргиох аргаар нягтшилтыг тооцож гаргадаг.

Модны титмийн дор 10х10 метр хэмжээтэй дэлгэц материалыг дэлгэж тавиад 1.7-2.0 метр урттай, 16 см орчим голчтой модон мунаар гол ишийг цохиж доргион дэлгэцэн дээр унасан шавжийг зүйл бүрээр ялгаж тооллого явуулж нягтшилтыг тооцож гаргана.

Мөчрийн арга

Хүрэнцэр хүүхэлдэйн тоог гаргахдаа мөчрийн аргыг хэрэглэж болно. Диаметр нь 2 см-ээс хэтрэхгүй мөчрийг үлгэр болгон авч түүнийгээ хоёр тэнцүү хэсэгт хуваан хүрэнцэр, хүүхэлдэйн тооллогыг хийнэ. Уг модонд байгаа хүрэнцэр, хүүхэлдэйн тоог дараах томъёогоор тооцно.

$$V = N \sqrt{2} X (F_1 + F_2) d$$

V – уг модонд байгаа хүрэнцэр, хүүхэлдэйн тоо \ширхэг\,

N – сонгосон үлгэр мөчрийн урт \см\,

F₁, F₂ – тайрдас тус бүр дээрх хүрэнцэрийн тоо,

d – сонгосон үлгэр мөчрийн тоо.

Квадратын арга

Ойн хөвхөн давхарга болон хөрсөнд байрлаж байгаа хөнөөлт шавж, хаданд өндөглөсөн Өрөөсгөл хүрийн өндөг зэргийн нягтшилтыг гаргахдаа квадратын аргыг хэрэглэнэ.

Энэ аргын үед 0.5х0.5 метрээс баггүй хэмжээний талбайд тооллого явуулж нягтшилтыг тооцдог.

Нас бие гүйцсэн хөнөөлт шавжийн нягтшилтыг феромонт урхи, гэрлэн урхи гэх мэт аргаар тооцож болно.

3.5. Ойн хөнөөлт шавжийн голомт, тооны хөдлөл зүй, хэт олшролтыг тогтоох арга

3.5.1. Ойн хөнөөлт шавжийн голомтыг тогтоох

Агаарын температур, дулаан, хүйтний нөхцөл бүрэлдэн тогтсон, нарны илч хангалттай хүрэлцэхүйц, сийрэг хөрстэй, хөвд ихтэй, чийг тунадас хүрэлцээтэй, махчин, шимэгч шавжийн бүрдэл, тоо толгой бага, ойн өтгөрөл бага, залуу зулзаган мод ихтэй, идэш тэжээл хүрэлцэхүйц байдаг орчин зүйн таатай нөхцөл бүрэлдсэн ой нь ойн хөнөөлт шавжийн анхдагч буюу үндсэн голомт болно.

Ойн хөнөөлт шавж хоол тэжээл дутагдсан үедээ тус үндсэн голомтоос тал бүр тийшээ салбарлаж тархан туслах голомтыг үүсгэдэг.

Туслах буюу хоёрдох голомт нь үндсэн голомттой харьцуулахад хөнөөлт шавжийн тоо толгой цөөн, амьдрах нөхцөл тааруу, идэш тэжээл хүртээмж муу байдаг. Энд цөөн тохиолдолд ойн хөнөөлт шавж олшрон ой модонд хөнөөл учруулдаг. Ийм ойг хөнөөлт шавжийн туслах голомт гэж нэрлэнэ.

Эдгээр голомтуудаас гадна бас нүүдлийн голомт гэж байдаг. Өрөөсгөл хүр, сибирийн хүр, яacobсоны төөлүүр, шинэсний шилмүүс хуйлагч эрвээхэйн хүрэнцэр үндсэн ба туслах голомтоос мөлхөх буюу салхины урсгалаар хол зайд хаягдаж нүүдлийн голомт үүсгэдэг.

Эрвээхэйнүүд нисэж, эмэгчин эрвээхэй өндгөө тохиромжтой орчинд шахах зэргээр тархалтын голомт тэлэгддэг боловч үндсэн голомтоосоо хол тасарч бүрэн чаддаггүй.

Иймээс хөнөөлт шавжийн голомт үүсэж болох газруудад судалгааг тогтмол явуулж хөнөөлт шавж ой модны навч, шилмүүсийг идэж сүйтгэж байгаа байдал, хөнөөлийн түвшин, тэдгээрийн тархалтын цар хүрээг тогтоож тэмцэх арга хэмжээг төлөвлөх шаардлагатай байдаг.

Модны хөнөөлт шавжид идэгдэж, гэмтэж хөнөөгдсөн байдалд үнэлэлт өгөхдөө дараах байдлаар үнэлнэ. Үүнд:

- нийт навч, шилмүүсний 50-75 хувь нь идэгдсэн бол их,
- нийт навч шилмүүсний 25-50 хувь нь идэгдсэн бол дунд,
- нийт навч шилмүүсний 25 хувь түүнээс бага хэмжээтэй идэгдсэн бол бага нэрвэгдсэн гэж үздэг.

Ойн хөнөөлт шавжийн голомтыг илрүүлж ой зохион байгуулалтын материал ашиглан талбайн хэмжээг тооцож, тархалтыг гарган зураглал хийж цуглуулна.

3.5.2. Хөнөөлт шавжийн тооны хөдлөл зүй, хэт олшролтыг тогтоох арга

Ойн хөнөөлт шавжийн байгальд үржих, олшрох тооны хөдлөл зүйг дөрвөн үе шатанд хувааж үздэг. Үүнд:

Эхэн үе

Ой модны гол хөнөөлт шавжийн үрждэг амьдралын хамгийн тохиромжтой нөхцөл бүрэлдэж буй болоход сибирийн хүр, өрөөсгөл хүр, шинэсний шилмүүс хуйлагч, яacobсоны төөлүүр, бийр сүүлт зэрэг эрвээхэйнүүд үй олноороо нисэж эвцэлдээнд орж хамгийн дээд хэмжээгээрээ өндөг гаргана. Өндөгнөөс анхны хүрэнцэрүүд гаран ой модыг төдийлөн их хэмжээгээр идэж шарлуулж чаддаггүй. Энэ үеийг хөнөөлт шавжийн тооны өсөлтийн үе буюу эхэн үе гэж нэрлэдэг.

Хоёрдугаар үе

Хөнөөлт шавж цаашид үржин олшрох энэ үед байгаль дахь шимэгч болон махчин шавжийн тоо цөөн, ойн шувуудын нөлөө зохих хэмжээнд хүрэхгүй, өвчин үүсгэгчид бараг байхгүй байдаг бөгөөд ойн хөнөөлт шавжийн хөгжилд тохиромжтой цаг агаарын нөхцөл бүрэлдсэн тохиолдолд ой модонд асар их хөнөөл учруулж эхэлдэг.

Хөнөөлт шавжийн тоо толгой дээд цэгтээ хүрч нэг модонд дунджаар 4000-25000 хүртэл олширч модны навч, шилмүүс, нахиа, найлзуур зэрэг бүх эрхтнээр хооллож ой модыг ахар богино хугацаанд хувхайлан идэж хатаана. Энэ үе нь 1-3 жил үргэлжилдэг боловч хөнөөлт шавжийн зүйл бүрт өөр өөр байна.

Энэ үед тухайн хөнөөлт шавжиар хооллогч ашигтай шавж, шувууд үржин олширч элдэв халдварт өвчин дэлгэрэх тул тэдгээрийн цаашдын тархалтын цар хүрээ, тоо толгой эрс хязгаарлагдана.

Нөгөө талаас идэш тэжээлийн нөөц хүрэлцэхгүй болж эхэлдэг. Энэ үеийг үй олноор үржих үе буюу хоёрдугаар үе гэж нэрлэнэ.

Гуравдугаар үе

Навч, шилмүүс, нахиа, найлзуур, залуу мөчрийг хүртэл идэж дуусгасны улмаас хөнөөлт шавжид идэш тэжээлийн хомсдол бий болж өлсгөлөн байдалд орно.

Мөн тэдгээрээр хооллогч махчин, шимэгч зэрэг ашигтай шавж, шувуу болон өвчин ихээр гардаг тул цаашид үржих боломжгүй болж үржлийн уг голомт бууралтанд орно. Энэ үе 1-2 жил үргэлжилнэ.

Дөрөвдүгээр үе

Хөнөөлт шавжийн тоо толгой байгалийн тэнцвэрт байдалдаа хүртэл буурах тул ой модонд хор уршиг тарихаа больж, идэгдсэн ургамал бараг үзэгдэхээ болино.

Энэ үеийг дөрөвдүгээр үе буюу епопуляци хэвийн байдалдаа орсон үе гэнэ. Энэ үед хортон цөөрч үүнийг даган түүгээр хооллогч шавж, шувууд хомсдон, өвчин эмгэг эрс багасна.

Тооны хөдлөл зүйн эхний хоёр шатанд оновчтой хугацааг сонгож тэмцлийн ажлыг явуулдаг.

Ойн хөнөөлт шавжийн тооны хөдлөл зүй аль шатандаа явааг популяцид тооны болон чанарын шинжилгээ хийж тогтоодог.

Чанарын шинжилгээ

Чанарын шинжилгээгээр дараах үзүүлэлтүүдийг тодорхойлог. Үүнд:

А. Гол төлөв хүүхэлдэй буюу эрвээхэйн шатанд эрэгчин эмэгчин шавжийн тооны харьцааг судалж тогтооно. Олшролын эхний шатанд эр, эм шавжийн тооны харьцаа тэнцүү байна. Олшролын дараагийн шатуудын идэш тэжээлийн хүрэлцээнээс шалтгаалж эрийн тоо эмийн тооноос бага болж эм нь давамгайлна.

Б. Ойн хөнөөлт шавжийн биеийн өнгөний хувьсалыг судалж тогтооно. Хөнөөлт шавжийн биеийн өнгө олшролын явцад хувирдаг. Өнгөний хувирал хүрэнцэр,

эрвээхэйн шатанд тод ажиглагдана. Олшрол ихсэх тутам биеийн өнгө бараан болдог.

В. Паразит болон махчны нөлөөг судлаж тогтооно. Олшролын эхний шатанд паразит болон махчин бараг байдаггүй бөгөөд хоёрдугаар шатнаас тоо хэмжээ харьцангуй ихсэж, гуравдугаар шатандаа дээд цэгт хүрч хөнөөлт шавжийн олшролд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг.

Тооны шинжилгээ

Ойн хөнөөлт шавжийн хөнөөл, олшролын байдлыг тодорхойлоход тооны шинжилгээг хэрэглэдэг. Тооны шинжилгээгээр үнэмлэхүй, буюу харьцангуй нягтшилт, үржлийн коэффициент, тархалтын коэффициент гэсэн үзүүлэлтүүдээр тодорхойлно.

А. Үнэмлэхүй нягтшилтыг тогтоохдоо нэг мод, нэг мөчир, нэг метр квадрат дахь хөнөөлт шавжийн тоо хэмжээг тогтооно. Үүнийг ойн нягтшилтыг тооцох аргын үед дэлгэрэнгүй үзсэн байгаа.

Б. Харьцангуй нягтшилтыг ажиглалтын талбай дээрх нийт модны хэдэн хувь нь хөнөөлт шавжинд нэрвэгдсэн болохыг хувиар илэрхийлэн тогтооно.

В. Үржлийн коэффициентийг тухайн жилийн буюу өнгөрсөн жилийн үнэмлэхүй нягтшилтын харьцаагаар тодорхойлдог бөгөөд нилээд чухал үзүүлэлт юм. Хэрвээ үржлийн коэффициент нэгээс их бол хөнөөлт шавжийн тоо өсч байгааг харин үржлийн коэффициент нэгээс бага бол хөнөөлт шавжийн тоо буурч байгааг харуулдаг.

$$P_{гр} = P_{a2} / P_{a1}$$

$P_{гр}$ – үржлийн коэффициент,

P_{a2} – өнгөрсөн жилийн нягтшилт,

P_{a1} – энэ жилийн нягтшилт,

Г. Тухайн жилийн ба өмнөх жилийн харьцангуй нягтшилтын харьцаагаар тархалтын коэффициентийг тодорхойлдог. Энэ үзүүлэлт нь хөнөөлт шавжийн тоо хэмжээ тархалт, хөнөөлийн байдал ихсэж багасаж байгааг илтгэдэг. Хэрвээ

тархалтын коэффициент нэгээс их бол хөнөөлийн хэмжээ ихсэж байгааг, нэгээс бага бол багасаж байгааг илтгэнэ.

$$KL = PrL_2 / PrL_1$$

KL – тархалтын коэффициент,

PrL₂ – энэ жилийн харьцангуй нягтшилт,

PrL₁ – өмнөх жилийн харьцангуй нягтшилт,

3.6. Мониторинг судалгааны арга зүй

Мониторинг судалгаа

Мониторинг гэдэг нь хүн болон байгалийн хүчин зүйлийн нөлөөгөөр хүрээлэн буй орчин, экосистем, амьтан, ургамлын бүлгэмдэл өөрчлөгдөх үйл явцыг урт хугацааны турш

- Ажиглалт
- Үнэлэлт хийж
- Урьдчилан таамаглах зэрэг цогц үйл ажиллагаагаар тандан судлах явдал юм.

Мониторинг судалгааг хамрах цар хүрээгээр нь орон нутаг, бүс нутаг, тив, дэлхийн гэж ангилан үздэг. Судалгааны арга зүй нь нэгд дахин давтагдах чанартай байдаг ба энэ нь тухайн мэдээнд дүгнэлт хийхийн тулд уг судалгааг олон удаагийн давтамжтай хийх шаардлагатай болдог гэсэн үг. Эхний удаагийн судалгаа нь таамаглал гаргах боломжийг олгодог ч, бодит дүгнэлтийг хийхэд хангалтгүй байдаг.

Ховор ховордож буй зүйлийг хамгаалах менежмент нь тухайн популяцийн өөрчлөлт, түүнд нөлөөлж буй хүчин зүйлийг тодорхойлох дээр тулгуурладаг. Мониторинг судалгааг явуулахын тулд судлаач, мэргэжилтэн, байгаль хамгаалагч нар тодорхой арга зүйг эзэмшиж хариуцсан нутагтаа тухайн амьтны судалгааг байнга давтан хийх шаардлагатай. Ийм судалгааг өргөн уудам нутгийг хамруулан хийж чадвал тухайн зүйлийн тархац, нягтшил, бүлгэмдэлийг тодруулах бүрэн боломжтой (2).

Судалгааны техник хэрэгсэл, хэрэглэхүүн

Эм урвалж: 70%-ийн этилийн спирт, формалин, этил ацетат, хлороформ, глицерин

Хяналт мониторингийн судалгаа хийж гүйцэтгэхэд материал цуглуулах, техник технологийн боломж тодорхой хэмжээгээр хангагдсан байх ёстой.

Үүнд: газрын зураг (1:100.000-ын масштабас багагүй), GPS, судлаачийн бөглөх маягт, зургийн аппарат, тэмдэглэлийн дэвтэр харандаа, 5-10м-ийн метр,


30-50м-ийн туузан метр, алхааметр, ховой, үхүүлэх сав, гэрлэн урхи, нүхэн занга, лонхон урхи, цахилгаан үүсгүүр, өгөөш, хямсаа, дусаагуур, сорогч багаж, модон хайрцаг, хөх, улаан, шар тавагнууд, дээжний зориулалтын том жижиг таглаа сайтай сав, дээж цуглуулах гялгар болон цаасан уут, хөвөнт зулдас, фильтерийн цаас.

Зарим багажийг дэлгэрэнгүй танилцууъя:

Үхүүлэх сав (killing jar)


Шавж үхүүлэх сав буюу морилька нь том амсартай, сайн эргэддэг тагтай ихэнхдээ шилэн байвал сайн. Энэ шил нь янз бүрийн хэлбэртэй байж болно. Гэхдээ хэтэрхий том байвал бас зохимжгүй.

Ихэвчлэн этил ацетатыг шавж унтуулах, үхүүлэх бодис болгодог. Учир нь бусад бодисыг бодвол ууршилт бага, хүнд хор болох нь харьцангуй бага юм. Этил ацетатыг бага зэрэг нэмэх байдлаар морилькоо дахин амархан цэнэглэнэ. Зарим шавж үхсэн мэт байх боловч сэргэх магадлал өндөр байдаг учир зарим судлаачид хэрэглэх дургүй байдаг. Этил ацетатаас гадна хлороформ, эфир, хумсны будаг арилгагч ацетоныг хэрэглэж болно.




Сорогч багаж

Ховойгоор барьсан шавжийг ялангуяа гар болон хямсаагаар барихад төвөгтэй эсвэл хурдан хөдөлгөөнтэй шавжийг барихад сорогчийг хэрэглэдэг. Шавж цуглуулж яваа үедээ сорогч багажийг унагах, төмөр чулуу мэт хатуу зүйлд цохиж доргиосноос хагарч болзошгүй тул ямагт болгоомжтой байх хэрэгтэй.



Шавжийн ховой (net)

Шавж цуглуулахад хамгийн түгээмэл хэрэглэдэг багаж бол ховой юм. Ховой нь стандартын дагуу 30см диаметртэй, бариул нь 120 см бүхий 60-70см цагаан өнгийн юүлүүр хэлбэртэй нарийн торлосон тортой байдаг.



Шавжийн майхан (Malaise trap) урхи

Майхан хэлбэртэй, доод хэсэг хар бараан, дээд хэсэг цагаан, шар, хөх өнгөтэй, оройд шавж үхүүлэх савтай, торон материалаар хийгдсэн сарьсан далавчтан (Hymenoptera), хос далавчтан (Diptera)-ы багийн шавжийг барихад зориулагдсан шавжийн том урхи.



Нүхэн занга (Pitfall trap)

Нүхэн занга янз бүрийн хэлбэр загвартай байж болно. Нүхэн зангыг гарын доорхи материал болох янз бүрийн лаазны амсрыг зүсэж, зурагт үзүүлсэн байдлаар тавина. Дээрээс нь тодорхой зайтайгаар амсрыг хагас тагласан байдалтай мод, чулуугаар эвж, хавтгай мод, төмрөөр хагас таглан дээжийг бороо орох, хэт халах, дайсан амьтанаас сэргийлнэ.



Лонхон урхи (юүлүүр хэлбэрийн урхи) –(Bottle trap)

Энэ арга нь мөн гарын доорх материалаар хийж шавж барих занга юм. Хоёр хуванцар сав аваад нэгийг хүзүүгээр, нөгөөг ёроолоор нь тайрч 2 амсарыг хэрэглэнэ. Томынх нь дээрээс хүзүүгээр тайрсан амсараар урт утас уяж, бөглөөг авч хийнэ.

Утсыг гадна талын амсраар гаргаж, сайн бэхлэж уяна. Тэгвэл энэ 2 сав холбоотой болно. Эсвэл 2 савыг угсарч үдээсний машинаар үдэж ч болно. Юүлүүрийн амсарт 2 цоолж, утсаар бариул гарган, өгөөшөө дотор нь хийж модонд өлгөж байрлуулна.



Тавган урхи (Pan trap)

Энэ шавж барих урхины онцлог хурц тод (ихэвчлэн шар, хөх, улаан) өнгийг ашиглаж шавжийн анхаарлыг атаж дууддаг арга юм.

Энэ урхийг тавиад ус (өгөөш) ууршихаас сэргийлэн эргэж, дээжээ авч байх шаардлагатай.

Дутагдалтай тал нь хүчтэй салхи, аадар борооноор хийсч ус нь хальж дээж урхины гадуур асгарах талтай. Дээжээ тавган урхиас шүүлтүүрээр шүүж дараа нь спирттэй саванд шилжүүлж хийнэ.



Судалгааны талбай сонгох

Судалгааны талбайг 3 хувилбараар тус бүр 1 га талбай сонгоно.

А. Тэмцлийн ажил явуулах газарт (судалгааг хор цацахын өмнө, хор цацсны дараа)

Тэмцлийн ажил хийхийн өмнө, хийх явцад, дараа нь тухайн газарт мониторинг хийх зорилготойгоор энэ талбайг сонгоно.

Б. Тэмцэл хийх болон хийхгүй газарт 2 талбай

Б хувилбарын талбайг сонгохдоо


- Ойн хэвшил
- Өндөршил
- Ургамлын хэв шинж
- Газарзүйн тогтоц зэрэг нь ойролцоо ба 2 талбай хоорондоо ойрхон боловч хор цацах явцад бие биедээ хамааралгүй талбайг сонгоно.

Тэмцлийн ажил явуулснаар гарах үр дүнг тооцоход дээрх сонгосон газарт хийсэн судалгаа хангалттай сайн үр дүн гарахгүй байж болох учир энд хяналтын талбай болгож тэмцэл хийхгүй газрыг сонгож авна.

В. Хөнөөлт шавжийн голомттой тэмцэл хийхгүй газарт (энэхүү талбайд хэрэв хөнөөлт шавжтай тэмцлийн ажил хийхгүйгээр байгаль дээрх процессыг ажиглах зорилготой.)

Дээж авах хэлбэр сонгох, дээж авах

Шавжийн бүлгэмдэл, нягтшилыг тогтоохдоо доорхи хэлбэрээс газрын гадаргуугийн хотгор гүдгэрээс шалтгаалан сонгож авна (Ногнайжав, 2003).



1-5 цэгийн, 2- Шатрын хөлөг, 3- Ташуу (Диагональ), 4- 5 цэгийн огтлолцсон ташуу, 5- "Z" үсгэн, 6-огтлолцсон ташуу

Үүнд: их хэмжээний талбайд "Z", газрын тогтоц нь хотгор гүдгэр ихтэй бага хэмжээний талбайд бол шатрын хөлөг, уулын энгэр, өвөрт ташуу, огтлолцсон нэх мэт

Сонгосон хэлбэрт нийт 5-аас дээш удаа шавж амьдарч болох бүх стацуудаас (өвс ургамал, мод, газар (геофилл) дээрх) шавжийг доорх арга зүйн дагуу цуглуулж, 70%ийн этилийн спиртэнд хийж хадгалах эсвэл үхүүлэх саванд үхүүлэн хөвөнт зулдас дээр тавьж, судлаачийн мэдээлэл цуглуулах хүснэгт бөглөн, кодыг дээжинд бичиж хийнэ.

Тухайн газраас дээжийг 3-аас дээш удаагийн давталттайгаар тодорхой хугацаанд авна. Жнь: 5, 6, 7, 8, 9 сарын дундуур.

Шавжийн бүлгэмдлийн зүйлийн олон янз байдал, элбэгшил, зүйлийн баялаг нь тухайн ойн хэв шинж, ургамалжилт, газарзүйн онцлогоос шалтгаалан харилцан адилгүй. Тухайн шавжийн зүйл бүрийн амьдралын онцлог, хөгжлийн мөчлөг, амьдрах газар орон янз бүр бөгөөд хөнөөлт шавжийн тэмцлийн үед мод, бут сөөг, өвслөг ургамал дээр амьдардаг, зөөлөн биетэй, нисдэг шавж ихээр өртөх боломжтой. Үүнд: сарьсан далавчтан (Hymenoptera), хос далавчтан (Diptera), хайрсан далавчтан (Lepidoptera), хагас хатуу далавчтан (Hemiptera), хатуу далавчтан (Coleoptera), ижил далавчтан (Homoptera)-ы багийнхан орно. Эдгээр шавж нь ойн хөнөөлт шавжтай нэгэн бүлгэмдэлд оршиж, орон зай, зарим нь идэш тэжээлийн хувьд өөр хоорондоо харилцан хамааралтай байж, популяцийн тоо толгойн хэлбэлзэлд нөлөөлж байдаг. Иймд цуглуулга хийхдээ эдгээр шавжийн цуглуулгыг сайн хийх хэрэгтэй.

Модны гол, иш мөчир, холтосны ан цав завсарт орших шавжийг хямсаагаар түүнэ. Жижгийг мөн соруулаар сорно. Үүний дараа хаана ургасан ямар мод бутнаас хэзээ, хэн уг материалыг цуглуулсан тухай хаяг бичиж үхүүлэх саванд хийнэ.

Ховойн аргаар шавж цуглуулах

Шүүрдэхдээ ховойн ам бүхий цагирагийг хажуу тийш харуулан босоо тэнхлэгт барих буюу бага зэрэг хазайлган эрс огцом хурднаар хоёр тийш дараалан ширвэн шүүрдэж ховойдолтын завсар ховойн уутыг цагираг дээр нугалан тохож тавина. Тэгвэл ховойд орсон шавж гадагш гарахгүй.

Ховойгоор шавж цуглуулахдаа ургамлын эвшил бүлгэмдэл тус бүрээс нэг удаагийн дээж авалтанд 15-20 удаа шүүрдэх бөгөөд зөвхөн хуурай ургамал дээр хийнэ. Учир нь өглөө эрт, оройн цагт ургамал чийг шүүдэртэй, бороотой үед шавж цуглуулахад ховой, түүнд орсон шавж норж бие эрхтэн нь гэмтэн өнгө зүсээ алдаж ангилалзүйн боловсруулалт хийх шаардлага хангадаггүй. Ховойнд орсон шавжийг алдалгүй нэг дор бөөгнөрүүлж түүн авахын тулд ховойгоо агаарт хэд дахин хий сэгсэрч ховойны ёроолд унаган, эфир, хлороформ шингээсэн хөвөн, марль, уудаг цаасыг ховойндоо хийж муужруулаад хямсаа, сорогч багажны тусламжтайгаар үхүүлэх саванд хийж бүрэн үхүүлнэ. Үүний дараа товч бичиглэл эсвэл судлаачийн бөглөх маягт дээр тавьсан кодыг бичиж үхүүлэх сав тус бүрд хийнэ. Ховойгоор шүүрдэлтийн тооцоог хийхдээ хөдөлгөөн багатай шавж дээр хийвэл тун тохиромжтой байдаг.

Майхан урхиар шавж барих

Майхан урхийг зааврынх нь дагуу угсарч тавихад түүн дээр буусан шавж гэрэлд тэмүүлэх чадвараараа дээш авирсаар үхүүлэх саванд ордог. Мөн түүнийг шөнө гэрлэн урхи болгож болно. Гэрлийг түүний онгорхой хэсгийн эсрэг

дээд талд байрлуулна. Ихэнх хөнөөлт эрвээхэй шөнийн идэвхитэй учраас түүнийг гэрлэн урхиар барьдаг.

Малайз урхийг хэдэн хоногоор тавихдаа үхүүлэх саванд спирт хийнэ. Харин богино хугацаагаар тавих бол этил ацетат, эфир, хлороформоор 2 цаг тутамд цэнэглэж байх хэрэгтэй. Үхүүлэх саванд спирт хийсэн тохиолдолд орсон шавжийг хамгийн багадаа 7 хоногт нэг удаа авч спирттэй саваа цэнэглэнэ.

Тавган урхиар (Pan trap) шавж барих

Нийтлэг загвар хавтгай бөгөөд дотор нь усны гадаргуугийн даралтыг багасгах бодис бага зэргийг хольсон ус хийнэ. Ингэхэд шавж уг тавганд ороод шууд савны ёроолд живнэ.

Хоорондоо нэг метрийн зайтай арваас дээш тавгийг цувуулан тавьж шавж цуглуулахад илүү үр дүнтэй. Энэ аргыг ялангуяа ойн зах, нуга зэрэгт тавьж цэцгийн тоос, балаар хооллогч шавжийг цуглуулна. Энэ урхиар олон янзын шавж ялангуяа хальсан далавчтан, хос далавчтан, тэр дундаа жунгинуур ялаа (Syrphidae) зарим ургамлын бясaa барихад өндөр үр дүнтэй.

Нүхэн занга (Pitfall trap)аар шавж барих

Голдуу хуурай болон нойтон нүхэн занга байдаг. Хуурай нүхэн занга нь газарт ямар нэгэн савны амсарыг (лааз, шил, бортого) газрын гадаргуутай ижил түвшинд байрлуулан, газарт булна. Шавж түүн дотор унах ба дээш өгсөж гарч чадахгүй. Нойтон нүхэн занга нь зарчмын хувьд ерөнхийдөө адил боловч савны ёроолд баригдсан шавжийг үхүүлж, хадгалах бодис (формалин) хийнэ. Өтгөн шигүү өвстэй, ойд унасан навч ихтэй амьдрах орчинд хоорондоо 2-3 метрийн зайтай 10 урхийг цувуулан тавина.

Ойр ойрхон шалгаж байх хэрэгтэй. Мөн нүхэн занга дотроо мах, аргал, жимс, үнэртэгч бодис зэргийг хийж болно. Дотроо өгөөшгүй бол жийгээ цох (Carabidae), аалз (Arachnidae)-ыг, өгөөштэй бол илтсэн сахалт цох (Scarabaeidae) болон бусад шавжийг цуглуулна.

Лонхон занга (Bottle trap)аар шавж барих

Модон дээр амьдардаг, үр жимсний хөнөөлт шавж ялангуяа илтэс сахалт цох (Cetoniinae дэд овог), эвэрт цох (Cerambycidae), сарьсан далавчтан (Hymenoptera), хэдгэнэ болон бусад нисдэг шавжийг цуглуулахад өргөн хэрэглэдэг.

Лонхон зангыг барих шавжаасаа хамааран бусад урхины адил хамгийн тохиромжтой газар тавина. Цохонд: модонд өндөрт, ялангуяа цэцэглэж, жимсэлж байгаа модонд өлгөнө. Ойн захад байрлуулвал олон шавж цугларах боломжтой. Ойн гүнд байрлуулвал ихэнхдээ цөөн тоотой боловч олон овог төрлийн шавж цугларах боломжтой. Хоорондын зай нь 15-20 метрийн зайтай шавжийн дээж авах хэлбэрийн дагуу модонд өлгөж байрлууна.

Урхи буюу зангаар шавж барихад өгөөш хийвэл шавж цугларах нь ихсэх учир дор өгөөшийн тухай товч дурдъя.

Олон төрлийн өгөөш хэрэглэдэг. Цох барихад шар айраг, дарстай эсвэл дангаараа гадил жимс, улаан дарс цагаан цуу элсэн чихрийн уусмал зэрэг. Сарьсан далавчтан, зарим буглаа цох барихад сироп, зөөлөн ундаа эсвэл чихэртэй ус.

Хөнөөлт шавжийн паразит шавжийг илрүүлэх, элбэгшилийг тогтоох

Зүйл идэш тэжээл ба газар нутгийн төлөө өрсөлдөхөөс гадна махчлалаар дамжин шууд харилцан үйлчлэлцдэг. Өргөн утгаараа махчлал нь нэг зүйлийн бодгалиуд нөгөө зүйлийн бодгалиудыг идснээр явагдана. Махчлал ихэнхдээ золиос организмыг үхүүлэх боловч заримд нь гэмтээж доройтуулдаг.

Махчлалын тодорхой 5 хэлбэр байдаг.

Ургамал идэштэнүүд ногоон ургамал, түүний үр жимсээр хооллох бөгөөд идэгдсэн ургамал бүрмөсөн үхдэггүй, зөвхөн гэмтдэг.

Ердийн махчлал нь махчид ургамал идэштэнээр эсвэл махан идэштэнээр хооллох үед тохиолдоно.

Паразитойд нь эзэн шавж дээрээ эсвэл ойр орчимд нь өндгөө гаргах бөгөөд эзэн шавж хожим нь уг паразитын хоол болно.

Шимэгчид нь эзэн организм дээр эсвэл дотор нь амьдардаг амьтан ургамлууд бөгөөд шим тэжээлийн бодисын хувьд эзэн организмаасаа хамааралтай байна. Тэд өөрсийн эзнээ бүрэн иддэггүй учраас нөлөөний хувьд ургамал идэштэнээс бага зэрэг ялгаатай.

Махчин золиос 2 нь нэг зүйлийн гишүүд байх ба *каннибализм* юм (Кребс, 2001).

Дээрх махчлалаас хөнөөлт шавжид ердийн махчлал, паразитойд, шимэгчид тохиолдох ба хөнөөлт шавжийн хувьд эдгээр нь биологийн хяналт болдог. Иймд судалгааны явцад улмаас байгаль дээрх ашигтай шавж, хөнөөлт шавжийн паразитууд хир нэрвэгдэж байгаа эсэхэд хяналт тавих шаардлагатай. Ойн хөнөөлт шавжийн өндөг, хүрэнцэр, хүүхэлдэй, бие гүйцсэн шатанд сарьсан далавчтан (Hymenoptera), хос далавчтан (Diptera)-ы багийн *Proctotrupidae*, *Scelionidae*, *Braconidae*, *Tachinidae*, *Bombyliidae*, *Anthomyiidae*, *Nemestrinidae*, *Muscidae* зэрэг нилээд олон овгийн шавж паразитладаг нь тогтоогдоод байгаа билээ. Паразит нь шавжийн хөгжлийн бойжилтын үе шат бүрт харилцан адилгүй хугацаанд халдварладаг тул өндөг, авгалдай, хүүхэлдэй, бие гүйцсэн шатанд тус тусад нь судална.

Өндөг, хүүхэлдэй шатанд байгаа шавж хөдөлгөөнгүй нэг газар байрладаг тул (тодорхой хэмжээтэйгээр) цуглуулан, инсектор дотор бойжуулж, улмаар паразит шавжийг гарган авч нэрвэгдэлтийн хувийг тооцно (халдварлагдалт).

Паразит шавжийг үргэлжлүүлэн бойжуулж түүнд ангилалзүйн боловсруулалт хийнэ. Инсектор байхгүй бол ариун нөхцөлд тасалгааны температурт ч бойжуулж болно.

Авгалдай, хүрэнцэр

А. Тэмцлийн ажил хийхийн өмнө 5-10 модны доор 6м-ийн радиустай цагаан даавуу дэвсэж, тэмцлийн ажлын дараа модыг нүдэж хүрэнцэрийг унагана. Мод тус бүрийн дээжийг тус тусд нь цагаан цаасан уутанд хийнэ. Нэгэнт үхсэн биеэс (дотор нь байгаа) паразит гадагшлах бөгөөд хэрэв паразитыг бие гүйцтэл нь бойжуулах бол инсекторт хийж бойжуулна. Тийм шаардлагагүй гэж үзвэл шууд 70%-ийн спиртэнд дээжийг хадгална. Мод тус бүрээс хэдэн хүрэнцэр унасан, хэдэн паразит гарсан зэрэг мэдээллийг маш сайн тэмдэглэж авна. Түүн дээрээ тулгуурлан нэрвэгдэлтийн хувийг мөн бодно.

Хүрэнцэрийн хамт модон дээр байсан болон ойр орчимд чөлөөтэй нисэж байсан шавж хоронд үхэж унаж ирэх боломжтой. Түүн дээр хувилбар А-ийн анализ давхар ажиглаж болно.

Эрвээхэй

Ойн хөнөөлт эрвээхэй ихэвчлэн шөнийн идэвхтэй байдаг тул шөнө гэрлэн урхиар мөн тодорхой тоотой бодгалийг барьж үхүүлэх лонхонд хийж үхүүлэн түүний паразит шавжийг илэрүүлэн нэрвэгдэлтийн хувийг тооцно.

Тэмцлийн ажил явуулсан болон явуулаагүй талбайгаас доорх шавж цуглуулах арга зүйн дагуу паразит шавжийн бие гүйцсэн бодгалийг цуглуулан, зүйлийн олон янз байдал, тохиолдоцын хэмжээ, нэрвэгдэлтийн хувиар тухайн паразитын элбэгшилийг тогтооно.

Дээжийг кодлох

Дээж хийсэн сав бүр тодорхой кодтой байна. Энэ нь тухайн дээж бусадтайгаа холигдож самуурахаас сэргийлэх бөгөөд хээрийн нөхцөлд аль болох хялбар аргаар, ойлгомжтой хэлбэрээр, нуршуу биш байхаар кодлох хэрэгтэй.

Он, сар өдөр, давталтын дугаар бичээд, паразит шавжийн дээж бол П, ховойгоор авсан бол Х, майхан урхиар бол М, нүхэн зангаар бол Н, лонхоор бол Л, тавгаар бол Т, гэсэн үсгүүдийг кодынхоо өмнө нь бичнэ. Жишээ нь П2011061103-үүнийг уншвал паразит шавжийн 2011 оны 6 сарын 11-ны 3 дахь дээж гэсэн утгатай байна.

Кодыг судлаачийн бөглөх маягтад болон дээжний саван дотор цаасан дээр балын харандаагаар бичиж хийнэ. Маягт, дээжний сав 2 ижил кодтой байх ёстойг хатуу анхаарах хэрэгтэй. Хэрэв код зөрөх, кодгүй дээж, маяганд боловсруулалт хийх ямар ч аргагүй юм.


Дээжид лабораторийн болон ангилал зүйн боловсруулалт хийх

1. Хээрийн судалгаагаар цуглуулсан шавжийг хөвөнт зулдасд гэмтээлгүй дэлгэж цуглуулсан газар орон, огноо, цуглуулсан хүний овог нэр зэргийг тэмдэглэж, лабораторид хүргэнэ.


2. Бие гүйцсэн шавжийг доорх шат дараалсан байдлаар боловсруулалт хийнэ. Үүнд: Хөвөнт зулдас дахь шавжийг ариутгасан, чийгтэй элстэй эксикаторт 3-5 хоног дэвтээж, дэвтсэний дараа тус бүрийг зүүнд хатгаж, сахал, хөл, далавчийг зохих шаардлагын дагуу тэнийлгэж хатаана.

3. Тодорхойлсон авгалдайг зүйл бүрээр ялгаж спиртэнд хийж хаягийг нэрийн хамт хийж хадгална.


4. Зүүнд хатгасан шавжид доорх хаягийг бичиж хатгаад, түүний доор зүйлийн латин нэрийг бичиж хатгана



Шавжийн далавчийг дэлгэж



Шавжид бичиж хавсаргах хаяг



Шавжийг зүүгээр хатгах газар баг ту бүрт өөр байна.

Янз бүрийн шавжийг зүүнд хатгах байдал

1. Бие гүйцсэн шавж, авгалдайн зүйлийн нэрийг тодорхойлох бичгийг ашиглан тогтооно.
2. Судалгааны явцад цуглуулгын цэгийн координатыг GPS-ээр тогтоож, энэ мэдээллийг шавжийн тархалтыг тогтооход ашиглана.

Хөнөөлт шавжийн олшролыг хязгаарлах, гамшиг болохыг урьдчилан мэдээлж сэргийлэх нь түүнийг устгах ажлын үндэс болно. Хөнөөлт шавжийн нягтшлыг тогтоох хэд хэдэн арга байдаг. Ангилал зүйн боловсруулалтыг шавжийн баг бүрт тохирсон тодорхойлох түлхүүр ашиглан мэргэжлийн шавж судлаачдаар хийлгэнэ. Энэ ажил нь маш хүнд хэцүү бөгөөд энгийн сонирхогч, мэргэжилтэн, байгаль хамгаалагчид хийж чадахгүй юм.

Судалгаанд боловсруулалт хийх

Тухайн газар нутгийн бүлгэмдэлийн хувиралтыг мэдэхийн тулд шавжийн зүйлийн олон янз байдлыг мэдэх шаардлагатай. Дээжин дэх зүйлийн тоо харьцангуй элбэгшилийг харгалзан үздэг хэд хэдэн хэмжүүр байдаг. Үүнээс бид хамгийн түгээмэл хэрэглэгддэг хетероген байдлын 2 хэмжүүрийг орууллаа.

Үүнд: Шэннон-Уинерийн (Shannon-Weiner) функц :

$$H = \sum_{i=1}^s (p_i)(\log_2 p_i)$$

H-зүйлийн олон янз байдлын индекс(бит/бодгаль)

S - зүйлийн тоо

p_i –нийт дээжид i - дугаар зүйлийн эзэлж буй хувь

Шэннон-Уинерийн функцэд олон янз байдлыг тодорхойлогч нь зүйлийн тоо, жигд тархалт буюу зүйл бүрт хамаарах бодгалийн тоо юм (Кребс, 1999). Энэ функцээр хэмжсэнээр зүйлийн тоо олшрох тусам зүйлийн олон янз байдал өсөх ба нэг зүйлд ноогдох бодгалийн тоо жигд байх тусам зүйлийн олон янз байдал ихэсдэг байна. Доорх томъёогоор жигд байдлын тархацыг олно.

$$E = H/H_{\max}$$

E - жигд тархац (0-1- ын хооронд утга авна)

H -тухайн бүлгэмдлийн зүйлийн олон янз байдал

H_{\max} - тухайн бүлгэмдлийн зүйлийн олон янз байдлын байж болох хамгийн их утга

Шэннон-Уинерийн индексээс гадна Симпсоны олон янз байдлын индексээр илэрхийлж болно.

$$D = \sum_{i=1}^s (p_i)^2$$

D -Симпсоны олон янз байдлын индекс

S - зүйлийн тоо

p_i –бүлгэмдэл дэх i - дугаарын зүйлийн бодгалиудын эзлэх хувь

Симпсоны индекс нь ховор зүйлийн хувьд харьцангуй бага жин, харин түгээмэл зүйлийн хувьд харьцангуй илүү жин оноодог дутагдалтай (Кребс, 2001).

Зүйлийн баялагийг 2 талбайд ялгаатай байгааг Mann Whitney-ийн шалгуураар тогтооно.

Тэмцлийн ажил явуулснаар тухайн бүлгэмдэл хувирч өөрлөгдөх хамаарлыг Spearman, Pearson-ы хамаарлын коэффициентээр илэрхийлнэ.

Зүйлийн баялаг, элбэгшил, олон янз байдал, жигд байдалыг хор цацсан, цацаагүй талбайд хийж, хооронд нь харьцуулахдаа статистик програмуудыг ашиглаж, нэгдсэн дүгнэлт гаргана.




Зураг № 1, 2. Хүрэнцэрийн тооллого явуулж байгаа нь



Зураг № 3, 4. Мод доргиож шавж илрүүлж тоолж байгаа нь



Зураг №5, 6. Дэлгэц дээр унасан шавжийн тооллого



Зураг №7, 8. Ойн хөнөөлт шавжийн тархалтыг зурган дээр тэмдэглэж байгаа нь

4. Судалгаа явуулсан газар нутаг

Судалгаанд Баян Өлгий аймгийн 7 сумын 77,064.0 га, Баянхонгор аймгийн 7 сумын 220,600.0 га, Ховд аймгийн 6 сумын 60,600.0 га, Говь Алтай аймгийн 5 сумын 41,736.0 га ой нийт 400,000.0 га хамрагдсан /Хүснэгт 1-6/.

Хүснэгт 1

Судалгааны ажлын гүйцэтгэл


№	Аймгийн нэр	Судалгаа явуулах төлөвлөгөө, га	Судалгаа явуулсан талбайн хэмжээ, давталтын тоо	
			Талбайн хэмжээ /га/	Судалгаа явуулсан тавталтын тоо
1	Баян- Өлгий аймаг	77,064.0	77,064.0	2
2	Баянхонгор аймаг	220,600.0	220,600.0	2
3	Говь-Алтай	41,736.0	41,736.0	2
4	Ховд аймаг	60,600.0	60,600.0	2
НИЙТ		400,000.0	400,000.0	-

Хүснэгт 2

Судалгааны ажлын үед байгуулсан дээж талбай

Д/д	Судалгааны багийн бүрэлдэхүүн	Хариуцсан чиглэл	Хамрагдсан сумдын тоо	Судалгааны дээж талбай	
				Суурин цэг	Маршрутын цэг
1	Ж.Жаргал, Э.Сарангуа, С.Ундрах, И.Доржжанцан Б.Мөнхбаатар	Баян- Өлгий аймаг	7 сум	-	7
		Баянхонгор аймаг	7 сум	1	10
		Ховд аймаг	6 сум	-	11
		Говь-Алтай	5 сум	-	10
		НИЙТ	26 сум	1	30

Судалгаа явуулсан талбайн хэмжээ /га/



Зураг № 9

Хүснэгт 3

Ховд аймагт ойн хөнөөлт шавжийн судалгаанд хамрагдсан газар нутаг талбайн хэмжээ

№	Сумын нэр	Газрын нэр	Судалгаанд хамрагдсан хэсэглэлийн дугаар	Судалгаа явуулсан талбайн хэмжээ /га/
1	Алтай	Бодончийн хавцал, Барлагийн хавцал, Анчиртын хавцал, Цонж өвдгийн үзүүр	1-45	18200
2	Булган	Харгайт, Индэрт, Тошилтын баруун салаа, Доод нарийн, Дээд нарийн, Жарын тохой, Яам, Шуудай	1-39	30000
3	Дарви	Ой бүхий газар нутгаар	1-11	1400
4	Мянгад	Чацаргана, Гахайт, Баянхошуу, Цагаан булан	1-4	4800
5	Үенч	Улиастайн хавцал, Рашаант, Харгайт, Үенчийн хавцал, Цагаан түнгэ	1-44	1800
6	Эрдэнэбүрэн	Хусны гол, Улиастайн гол, Шар араг, Шаазгай араг, Бор мод	1,2,3	4400
ДҮН				60,600.0

Хүснэгт 4

Баянхонгор аймагт ойн хөнөөлт шавжийн судалгаанд хамрагдсан газар нутаг талбайн хэмжээ

№	Сумын нэр	Газрын нэр	Судалгаанд хамрагдсан хэсэглэлийн дугаар	Судалгаа явуулсан талбайн хэмжээ /га/
1	Баянлиг	Зүүн тоорой, Баруун тоорой, Эмэгт хар хоолой, Ширээгийн гашуун, Бухтын улаан, Ширээ тээг, Таван загийн хоолой, Дунд хацавч, Өвөр чавчаалын сайр, Халтар загийн хоолой, Харцаг, Сэвсүүл, Зуун мод, Хар дов, Замт, Халзат дов	1- 22	60,000.0
2	Баяновоо	Уртын гол, Хуурай	1-4	600
3	Галуут	Ар мухарын мод, Цохион, Их, Бага Цохиот, Хуримт, Модот, Үхэг, Агт, Жаргалантын гол, Тээл, Уурагт, Их жаргалант, Нарт, Ёл, Хавцгайт, Өлзийт гол, Өргөөт, Дэлгэр,	1-53	40000
4	Жаргалант	Байдрагийн өргөн мод, Хүрээний буурь, Их уургат, Бага уургат, Нуур, өргөн мод, Цагаанхайрхан, Өлзийт мод, Баян мод, Модон ам, Тармаг, Өлзийт жаога	1-11	9000
5	Өлзийт	Зургаагийн мод, Бурхантай хошуу, Таргил, Агуйт, Ёл, Гялгарын хавцгай	1-5	1000
6	Эрдэнэцогт	Дөш, Цагаан мааньт, Өртөмт, Их бугат, Ар бугат, Нэвшээ	1-59	40000
7	Баян Өндөр	Заган ой бүхий нутгаар	1-38	70000
ДҮН				220,600.0

Хүснэгт 5

**Говь-Алтай аймагт ойн хөнөөлт шавжийн судалгаанд хамрагдсан газар
нутаг талбайн хэмжээ**

№	Сумын нэр	Газрын нэр	Судалгаанд хамрагдсан хэсэглэлийн дугаар	Судалгаа явуулсан талбайн хэмжээ /га/
1	Жаргалан	Хасагт хайрхан уул, Борхын гол, Зэс мод, Гол мод	1-22	17420
2	Халиун	Хар азаргын нуруу, Хаалгын эх, Мод толгой, Модон даваа, Шонт, Бургаст, Даваа, Баянгол, Могой, Хуст, Урд улиастай, Хөшөөт, Зэлийн гол, Ар гол ширээ, Ялаат, Дунд ус, Бөгтөр цагаан, Эрэг сайн ус	1-12	9228
3	Есөнбулаг	Адуун чулуу, Утаат, Зэгийн гол, Ямбатын тал, Дөрвөлжин, Шар заг, Хойд таван толгой, Шангын гол	1-6	3188
4	Шарга	Хасагт хайрхан, Тэвх, Баларын шар, Тэгш, Гоёо, Эгт	1, 2	11396
5	Тайшир	Улиастай, Дусаалын бэлчир, Шангын нуруу, Хүүхний мод, Завхан гол дагуу	1, 2, 3	504
ДҮН				41,736.0

Хүснэгт 6

Баян-Өлгий аймагт ойн хөнөөлт шавжийн судалгаанд хамрагдсан газар нутаг талбайн хэмжээ

№	Сумын нэр	Газрын нэр	Судалгаанд хамрагдсан хэсэглэлийн дугаар	Судалгаа явуулсан талбайн хэмжээ /га/
1	Алтай	Ёлтын ам	76, 77, 111	2600
2	Алтанцөгц	Хаш, Улаан харгана, Улаан хус, Зах ус, Бүхээлт, Ховд голын сав дагуу	6, 7, 10	12000
3	Баяннуур	Ховд голын сав дагуу, Цэцэгт, Цагаан арал, Шар тохой, Каратерек	8, 107-110	12000
4	Бугат	Буга, Хатуугийн гол, Ховд голын сав дагуу	11, 113	1200
5	Булган	Ойн сан бүхий нийт талбай хамрагдсан	86-89, 91-106, 102	30000
6	Дэлүүн	Хөх сэрхийн нуруу	84, 85	1000
7	Ногооннуур сум	Хавцал, Хатуугийн ам, Бөх мөрөн гоын сав дагуу	1-4	18264
ДҮН				77,064.0

5. Судалгааг гүйцэтгэсэн бүрэлдэхүүн

Судалгааны ажлыг дараах бүрэлдэхүүнтэй гүйцэтгэсэн /Хүснэгт 7/. Үүнд:

- Э.Сарангуа – шавж судлаач, экологич
- Ж.Жаргал – шавж судлаач, биологич,
- С.Ундрах – Ойн инженер,
- И.Доржжанцан – захирал,
- Б.Мөнхбаатар – Жолооч,
- Улирлын ажилтан - 3 хүн

Судалгааны ажлыг гүйцэтгэсэн багийн бүрэлдэхүүн

д/д	Судалгааны багийн бүрэлдэхүүн	Хариуцсан чиглэл	Хамрагдсан сумдын тоо	Судалгаанд хамтран оролцсон			
				Ойн нэгж	СДОА	БОХУБ	БХ
1	Ж.Жаргал, Э.Сарангуа, С.Ундрах, И.Доржжанцан Б.Мөнхбаатар	Баян- Өлгий аймаг	7 сум	1	1	-	7
		Баянхонгор аймаг	7 сум	1	-	3	7
		Ховд аймаг	6 сум	1	1	1	6
		Говь-Алтай	5 сум	1	1	1	5

6. Судалгааг гүйцэтгэсэн үе шат хугацаа

Судалгааны ажлыг дараах гурван үе шатаар гүйцэтгэсэн. Үүнд:

1. Зун явуулсан судалгааны ажил. Энэ судалгаагаар ойн хөнөөлт шавжийн биологи, экологийн онцлог, тархалтыг тогтоох, 2019 онд тэмцлийн ажил явуулах талбайг сонгох судалгааны ажлыг гүйцэтгэсэн. Энэ судалгааг 2018 оны 06 дугаар сарын 01-нээс 40 хоногийн хугацаанд гүйцэтгэсэн.

3. Намар явуулсан судалгааны ажил. Энэ судалгаагаар ойн хөнөөлт шавжийн биологи, экологийн онцлог, тархалтыг тогтоох, 2020 онд тэмцлийн ажил явуулах талбайг сонгох судалгааны ажлыг гүйцэтгэсэн. Энэ судалгааг 2019 оны 08 дүгээр сарын 20-ноос 45 хоногийн хугацаанд гүйцэтгэсэн.

7. Судалгааны ажлын бэлтгэл ажил

Судалгааны ажлыг гүйцэтгэхийн өмнө дараах бэлтгэл ажлыг хангасан. Үүнд:

- Судалгааны ажилд хэрэглэх автомашиныг ажилд бэлтгэсэн,
- Судалгаанд хэрэглэсэн багаж хэрэгсэлийг ажилд бэлтгэсэн,
- Судалгаанд хэрэглэх бодис /хлороформ, этил ацитат, спирт/, материал /хөвөн, өнгийн таваг, нэг удаагийн хуванцар аяга, гэх мэт/ зэргийг худалдан авч бэлтгэсэн,
- Улирлын түр ажилтан, оюутан нарт арга зүй эзэмшүүлэх сургалт явуулж, бүх ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөн ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар анхааруулга өгсөн,

- Судалгаа явуулах маршрут, зураглал гаргасан.

8. Судалгаанд хэрэглэсэн техник, багаж хэрэгсэл, хэрэглэхүүн

Энэ судалгаагаар ойн хөнөөлт шавжийн биологи, экологийн онцлог, тархалтыг тогтоох, 2019, 2020 онд тэмцлийн ажил явуулах талбайг сонгох, тэмцлийн ажлын үр дүнгийн болон үр дагаврын мониторингийн судалгааны ажлыг гүйцэтгэхэд хэрэглэсэн техник, багаж хэрэгсэл, хэрэглэхүүнийг хүснэгт 8-аар үзүүлээ.

Хүснэгт 8

Судалгаанд хэрэглэсэн багаж хэрэгсэл, машин техникийн жагсаалт

Д/д	Багаж хэрэгсэл, машин техникийн нэр	Тоо хэмжээ
1	Бичил цаг уур хэмжигч багаж	2 ширхэг
2	Газарзүйн байршил тодорхойлогч GPS багаж	4 ширхэг
3	Майхан	4 ширхэг
4	Дэлгэц материал	1
5	Шавж үхүүлэх, хадгалах сав	4
6	Зургийн аппарат	4
7	Камерь	1
8	Шавж барих ховой /сачок/	4
9	Сорогч багаж	4
10	Лонхон урхи	150
11	Тавган урхи	250
12	Модны диаметр хэмжигч	1
13	Өндөр хэмжигч	4
14	Хүрэнцэр хэмжих штангенциркуль	10
15	Шавж барих, тоолох тор	5
16	Митсубиши пажеро	1
17	Пургон автомашин	2
18	Старекс автомашин	1
19	Цахилгаан өсгөгч	1

9. Судалгааны үр дүн

9.1. Ойд хөнөөл учруулж буй шавжийн зүйл

Өнөөгийн байдлаар Монгол орноос 700 гаруй зүйлийн хөнөөлт шавж тэмдэглэгдээд байгаагийн дотроос 7 баг, 56 овог, 168 төрөл, 600 орчим зүйлийн шавж жил бүр их, бага ямар нэгэн хэмжээгээр ойд хөнөөл учруулж байдаг.

Эдгээрээс их хэмжээний газар нутаг дэвсгэрийг хамран тархсан Сибирийн хүр, Якобсоны төөлүүрч, Бургасны бийрэн сүүлт, Энгийн бийрэн сүүлт, Шинэсний шилмүүс хуйлагч эрвээхэй, Шинэсний холтосч том цох, Алтайн ба нарийн сахалт эвэрт цох, Шинэсний урын ялаа, Зургаан шүдэт холтосч цох,

Нарсны мөлгөр цох, Нарсны үрийн давирхайч, Сибирийн хатан ногоон жуулга, Шинэсний шөвгөр хошуут зэрэг 40 гаруй зүйлийн онцгой аюулт гоц хөнөөлт шавж Хангай, Хэнтий, Хөвсгөл, Алтайн уулархаг мужийн аль их ойтой хэсэгт нилээд хэмжээгээр тархаж, чийг, хур тунадасаар дутмаг, хуурайшилт ихтэй жил ахар богино хугацаанд үй олноороо үржин их хэмжээний ой модыг хөнөөн сүйтгэсээр байна.

Бидний явуулсан судалгааны дүнгээс үзэхэд судалгаа явуулсан газруудад Хайрсан далавчтан *Lepidoptera* -ы багийн Хүр эрвээхэйн овог *Lasiocampidae* -ийн овгийн 1 зүйл *Denrolimus sibiricus* Tschetw), Бийр сүүлтийн овог *Orgyidae*-ийн 3 зүйл *Lymantria dispar* Linn, *Orgyia antique* Linn, *Stilpnotia salicis* Linn), Навч хуйлагчийн овог *Tortricidae* -ийн 1 зүйл *Zeiraphera diniana* Gn), Төөлүүрийн овог *Geometridae*-ийн 1 зүйл *Erannis jacobsoni* Diak) тархан хэт олширсон үедээ хөнөөл учруулж байна.

Үр боргоцойн хөнөөлт шавжаас Шинэсний ялаа *Lasiomma laricicola* Karl) гол ишний хөнөөлт шавжиас Жодооны том эвэрт цох *Monochamus urusovi* Fisch) зэрэг хөнөөлт шавжууд тохиолдож байсан.

Сибирийн хүр эрвээхэй

(*Dendrolimus sibiricus* Tshetv)

Хайрсан далавчтаны (*Lepidoptera*) баг хүр эрвээхэй (*Lasiocampidae*)-н овогт орно.

Өмнөд далавч нь саарал өнгөтэй, дээд талдаа хар хүрэн судлуудтай, түүний хоёр нь далавчны үзүүрт ойрхон байрладаг. Далавчны дээд хэсэгт муруй тахир судал байх ба голын хэсэгтээ цагаан толботой.

Эрвээхэйн бие үнсэн саарал ба хар саарал үсээр бүрхмэл юм. Эрэгчний сахал нь дэл хэлбэртэй, эмэгчнийх богинохон дэлэрхэг хэлбэртэй байдаг. Далавчны дэлгэмэл эмэгчнийх 65-90 мм, эрэгчнийх 50-80 мм урт.

Нэг эмэгчин эрвээхэй дунджаар 250-330 ширхэг өндөг гаргадаг бөгөөд өндөгнөөс 15-25 хоногийн дараагаар хүрэнцэр бий болж 2-3 удаа гуужин томорч, биеийн урт 0.1-0.5 см болохын хамт 9-р сарын эхээр хөрсний өнгөн хэсэгт 2-6 см-ийн гүнд орж ичдэг. Дараа жилийн хавар 4-р сарын сүүлч 5-р сарын эхээр ичээнээс гарч модонд авиран, намар орой болтол 3-4 удаа гуужиж, өсөж томорсоны эцэст 53.3 мм орчим урттай болж, дахин хөрсөнд орж ичдэг. Дараа жилийн хавар ичээнээс гарсан хүрэнцэр богино хугацаанд хэд хэдэн удаа гуужиж, хөгжин 8.5 см хүртэл өсдөг ба 5-р сарын дунд үеэс 6-р сарын сүүлч хүртэл 35-40 хоногийн дотор модны шилмүүсийг асар богино хугацаанд идэж сүйтгэдэг. Өөрөөр хэлбэл 3-дахь жилдээ ичээнээс гарсан хүрэнцэр нь хүүхэлдэй, бие гүйцсэн эрвээхэй болоод эвцэлдээнд орж өндгөө шахаад үхэх хүртэлх хугацаандаа хэрэглэгдэх идэш тэжээл бүхий энергээ нөхөн авдаг. Нас гүйцсэн хүрэнцэрийн хоёр, гуравдугаар цагираг дээр хөхөвтөр туяатай, хөндлөн

хар судалтай, богинохон үстэй, харин 3, 4-р үеүд дээр хар хөх өнгийн багц үс бий. Биеийн бүх гадаргуу нилээд урт үсээр бүрхмэл ба нуруун талынх хар өнгөтэй, хажуу талынх мөнгөлөг саарал өнгөтэй.

Хүүхэлдэй хар хүрэн буюу хар өнгөтэй, 40-60 мм урт.

Сибирийн хүр эрвээхэйн хүрэнцэр бүх төрлийн модонд хөнөөл учруулдаг. Гэхдээ ихэвчлэн Шинэс, Хушны шилмүүсээр хооллодог. 7-12 насны залуу шилмүүст модонд 10-24 ширхэг хүрэнцэр ноогдвол уг мод нөхөн ургах чадвараа 100 хувь алддаг байна. Идэш тэжээл хүрэлцэхгүй үед модны залуу мөчир, холтос, боргоцой зэргээр хооллодог байна.



Зураг№ 10. Сибирийн хүр эрвээхэйн хүрэнцэр,



Зураг№ 11. Сибирийн хүр эрвээхэйн хүүхэлдэй



Зураг №12. Сибирийн хүр эрвээхэйн өндөг

Сибирийн хүр эрвээхэйн хөгжлийн хуанли

Жил	5-р сар			6-р сар			7-р сар			8-р сар			9-р сар		
	1	2	3	1	2	3	1	2	3	1	2	3	1	2	3
Нэг дэх жил	≡	≡	≡	≡	≡	≡	≡	≡							
						◇	◇	◇	◇						
				℞	℞	℞	℞	℞							
							х	х	х	х					
								≠	≠	≠					
										⊙	⊙	⊙			
											-	-	-	-	-
											℞	℞	℞	℞	
Хоёр дахь жил		=	=	=	=	=	=	=	=	=	=	=	=	=	=
		℞	℞	℞	℞	℞	℞	℞	℞	℞	℞	℞	℞	℞	
Гурав дахь жил	≡	≡	≡	≡	≡	≡	≡	≡							
							◇	◇	◇	◇					
								х	х	х	х				
								≠	≠	≠	≠				
											⊙	⊙	⊙		
												-	-	-	-
		#	#	#	#	#	#	#	#	#	#	#	#	#	
		℞	℞	℞	℞	℞	℞	℞							
											℞	℞	℞		

□ - Өндөг

х - Эрвээхэй

- - 1-2 насны хүрэнцэр

□ - Хүүхэлдэй

= - 3-4 насны хүрэнцэр

□ - Эвцэлдээнд орох

≡ - 5-7 насны хүрэнцэр

□ - Тэмцэх хугацаа

- Гоц аюул учруулдаг үе

Өрөөсгөл хүр эрвээхэй

(*Osneria dispar* L)

Хайрсан далавчтаны (Lepidoptera) баг Оргид (Orgyidae)-ийн овог. Өрөөсгөл хүр эрвээхэйн эмэгчин эрвээхэй нь 8-р сарын сүүлч, 9-р сарын эхээр эвцэлдээнд орж, 350-450 ш өндгийг хад асга ихтэй бартаатай, тогтмол гэрэл гэгээтэй байдаг, байшингийн нүүр, төмөр замын буудал, модны ан цав завсар зэрэг янз бүрийн газар өндөглөнө. Өндөг үе шатандаа ил өвөлждөг. Өвөлжсөн өндөгнөөс хавар 5-р сард хүрэнцэрүүд гарч ирэхийн хамт модны аль залуу шилмүүс, навч нахиагаар хооллож, эхлэх бөгөөд их олширсон жилдээ модонд нэг ч навч, шилмүүс үлдээлгүй иддэг, ойн гол аюултай хөнөөлт шавж юм.

Хүрэнцэр 40-50 хоногийн туршид амьдрах хугацаандаа эр хүрэнцэр 5 удаа, эм хүрэнцэр нь 6 удаа гуужиж өсдөг. Хүрэнцэр нь 7-р сарын дунд үеэс эхлэн хүүхэлдэйн хөгжилд шилжиж, улмаар 15-20 хоногийн дараагаар эрвээхэй болно.

8-р сарын дундуур тогтуухан дулаахан өдөр Өрөөсгөл хүр эрвээхэй үй олноороо нисэж эвцэлдээнд орон өндөглөнө. Хад асган дахь өндөгнөөс хавар эрт анхны хүрэнцэр бий болохын хамт хэд хэдээрээ нийлж шүлсээрээ томоохон тор нэхдэг. Ингээд нэхсэн торны хамтаар алс газар хаягдан шинэ шинэ голомтуудыг үүсгэдэг.

Хавар эрт уул хад асга цагаан цайвар тороор бүрхэгдсэн байвал тэд Өрөөсгөл хүр эрвээхэйн хүрэнцэр байна гэсэн шинж тэмдгийг заахаас гадна уг торыг цуглуулан авч шатаах буюу устгаснаараа цаашид үржин олшрох замыг хааж болдог механик арга байдаг. Уг эрвээхэйн хүрэнцэр мод, модлог ургамлуудын навч, шилмүүсээр хооллоод зогсохгүй 300 гаруй зүйлийн ургамлаар хооллодог хөнөөлт шавж юм.



Зураг№13, 14. Өрөөсгөл хүр эрвээхэйн хүрэнцэр, Хүүхэлдэй

Өрөөсгөл хүр эрвээхэйн хөгжлийн хуанли

5-р сар			6-р сар			7-р сар			8-р сар			9-р сар		
1	2	3	1	2	3	1	2	3	1	2	3	1	2	3
☉	☉	☉	☉	☉										
				-	-	-	-	-	-					
									◊	◊	◊			
									+	+	+	+		
										‡	‡	‡		
										≠	≠	≠		
♠	♠	♠	♠	♠	♠	♠	♠	♠	♠	♠	♠	♠	♠	♠
			#	#	#	#	#	#	#	#				
												☉	☉	☉

- ☐ - Өндөг
- - Хүрэнцэр
- ☐ - Хүүхэлдэй
- # - Гоц аюул учруулдаг үе
- + - Ганц нэгээрээ нисэх үе
- ++ - Үй олноороо нисэх үе
- ☐ - Эвцэлдээнд орох
- ☐ - Тэмцэх хугацаа

Эгэл бийрэн сүүлт эрвээхэй

(*Orgyia antiqua* L.)

Хайрсан далавчтаны (Lepidoptera) баг, Оргийд (Orgyidae)-ийн овог. Эрэгчин эрвээхэй бор шаргал зүстэй, өмнөд далавчны хойд зах орчимд таслал маягийн тод цагаан толботой, дэл хэлбэрийн сахалтай, дэлгэмэл далавчны урт 25-30 см, эмэгчин эрвээхэйн далавч дөнгөж мэдэгдэм төдийхөн байдаг тул нисэж чаддаггүй, харин хөлний хөгжил сайн, бүдүүн махлаг биетэй, бор саарал өнгөтэй байдаг.

Өндөг нь бөөрөнхий хэлбэртэй хоорондоо нягт наалдсан, бүдэг сааралдуу өнгөтэй.

Хүрэнцэр бор хүрэн өнгөтэй, хэвлийнхээ төгсгөлд нэг, толгойн хойд хэсэгт ба хэвлийн хоёр хажууд нэг хос бор өнгийн бийр хэлбэрийн багц үстэй, хэвлийн 4-8-р цагираг дээр шар өнгийн сойз хэлбэрийн багц үстэй, биеийн урт 30-35 мм байдаг.

Хүүхэлдэй нь гялалзсан хар бараан өнгөтэй, 15-18 мм урт, биеийнхээ төгсгөлд гох дэгээтэй бөгөөд түүний тусламжтайгаар модны мөчрөөс зүүгдэн байрлана.

Эрвээхэй 7-р сарын сүүлч, 8-р сарын эхээр эвцэлдээнд ороод уг сарын дундуур өндөглөнө. Эмэгчин эрвээхэй өндгөө багц багцаар 230-300 ш өндгийг модны мөчир, холтос, ишний ан цав завсарт гаргадаг. Намар гарсан өндөг өвөлжиж дараа жилийн хавар мод нахиалах үеэр өндөгнөөс хүрэнцэр бий болж, модны залуу навч, шилмүүсээр хооллодог. Хүрэнцэр амьдралынхаа туршид 5 удаа гуужиж хөгжсөний эцэст хүүхэлдэйн шатандаа шилждэг. Хүүхэлдэйнээс 7-14 хоногийн дараагаар эрвээхэй гарч эвцэлдээнд орно. Бийр сүүлт эрвээхэйн хүрэнцэр шинэс, хус, бургас, гацуур, жодоо зэрэг модны навч, шилмүүсээр хооллодог. Увс, Завхан, Хөвсгөл, Өвөрхангай, Архангай, Хэнтий зэрэг аймгийн нутагт тархсан байна.



Зураг № 15, 16. Эгэл бийрэн сүүлт эрвээхэйн хүрэнцэр

3-р схем

Эгэл бийрэн сүүлт эрвээхэйн хөгжлийн хуанли

5-р сар			6-р сар			7-р сар			8-р сар			9-р сар		
1	2	3	1	2	3	1	2	3	1	2	3	1	2	3
☉	☉	☉												
		-	-	-	-	-	-	-	-					
								◊	◊	◊				
									+	+	+			
										‡	‡			
										≠	≠			
		#	#	#	#	#	#	#	#					
		♠	♠	♠	♠	♠	♠	♠	♠					
												☉	☉	☉

☐ - Өндөг

- - Хүрэнцэр

☐ - Хүүхэлдэй

- Гоц аюул учруулдаг үе

+ - Ганц нэгээрээ нисэх үе

++ - Үй олноороо нисэх үе

☐ - Эвцэлдээнд орох

☐ - Тэмцэх хугацаа

Якобсоны төөлүүрч эрвээхэй


(*Erannis jacobsoni* Diak)

Хайрсан далавчтаны (Lepidoptera) баг төөлүүрч (Geometridae)-ийн овог. Бие гүйцсэн эрвээхэйн биед хүйсний ялгаа буюу бэлгийн демофизм тод илэрдэг. Өөрөөр хэлбэл, эр, эм эрвээхэй өөр хоорондоо гадаад бүтэц, хэлбэрээрээ эрс ялгаатай байдаг. Эрэгчин нь тод цайвар өнгийн далавчтай түүний дэлгэмэл урт 2.5-2.8 см хүрдэг, өмнөд далавч нь бараан өнгийн хөндлөн судалтай, сам хэлбэрийн утаслаг сахалтай, эм эрвээхэй далавчгүй бөгөөд хар, цагаан өнгийн үсээр битүү хучигдсан тул энгийн нүдээр алаг өнгөтэй харагддаг. Биеийн урт 2 см. Тод шар өнгөтэй зуйван хэлбэртэй, барзгар гадаргуутай, урт нь 10 мм, өргөн нь 6-6.5 мм байдаг. Уг эрвээхэйн өндөг модны холтосны ан завсар байрладаг.

Хүрэнцэрийн бойжилт буюу гуужилтын тоо нь газар зүй ой ургамалжилтын онцлогоос шалтгаалж, тархсан газар бүрд харилцан адилгүй байна. Биеийн булчин, махбодь хөлний тусламжтайгаар идэш тэжээл хэрэглэхийн тулд төөлөх хэлбэрийн идэвхтэй хөдөлгөөн хийдэг. Ийм шинж уг овгийн хүрэнцэр түгээмэл тул төөлүүрч эрвээхэйн овог гэж нэрлэсэн. Шүлсний тусламжтай модны оройгоос доош буюу нэг мөчрөөс нөгөө мөчирт босоо чиглэлийн дагуу идэвхиүй шилжих хөдөлгөөн хийдэг. Хүрэнцэр нь 4-5 удаа гуужсаны дараа хүүхэлдэйн шатанд шилждэг.

Хүүхэлдэйн бие нь гялалзсан тод хүрэн өнгөтэй, гаднаа уутан бүрхүүлгүй чөлөөт хэлбэртэй, биеийн төгсгөл нь сэрээ хэлбэртэй хурц байна. Биеийн урт нь эр, эм хүүхэлдэйд ижил байдаг боловч биеийн өргөн нь эм хүүхэлдэйд эрийнхээс 0.3 мм-ээр, биеийн жин 10 мг-аар илүү байдаг. Хүүхэлдэй нь хөрсний өнгөн давхраанд толгойн хэсэг нь доош харан байрлана.

Якобсоны төөлүүрч эрвээхэйн хүрэнцэр шинэсний шилмүүсийг үгүйртэл идэж амьдралын хэвийн үйл ажиллагааг алдагдуулдаг. Судалгаанаас үзэхэд Якобсоны төөлүүрч эрвээхэй 1989-1990-ээд оны хэт олшролын дараа 2.7 мян га талбайн мод хатаж хуурайшин, хөнөөлд нэрвэгдсэн ойн жилийн өсөлт хэвийнхээс 64.2%-иар багасчээ.



Зураг 17, 18. Якобсоны төөлүүрч эрвээхэйн төөлүүр

4-р схем

Якобсоны төөлүүрч эрвээхэйн хөгжлийн хуанли

5-р сар			6-р сар			7-р сар			8-р сар			9-р сар		
1	2	3	1	2	3	1	2	3	1	2	3	1	2	3
☉	☉	☉												
		-	-	-	-	-	-							
							◊	◊	◊					
								+	+					
									++	++				
									≠	≠				
		#	#	#	#	#	#							
			♠	♠	♠	♠	♠							
										☉	☉	☉	☉	☉

- ☐ - Өндөг
- + - Ганц нэгээрээ нисэх үе
- - Хүрэнцэр
- ++ - Үй олноороо нисэх үе
- ☐ - Хүүхэлдэй
- ☐ - Эвцэлдээнд орох
- # - Гоц аюул учруулдаг үе
- ☐ - Тэмцэх хугацаа

Бургасны бийрэн сүүлт эрвээхэй

(*Stilpnotia Salicis* L)

Хайрсан далавчтаны баг, хүр эрвээхэй (*Lasiocampidae*)-н овог Бургасны хүр эрвээхэй Орхон, Сэлэнгэ, Хойд, Урд Тамир, Эг-үүр, Түйн, Дэлгэр, Завхан, Тарвагатай, Цэнхэр, Цэцэрлэг, Туул, Гацуурт зэрэг голын ай саваар тархсан байдаг боловч өнөөгийн байдлаар Архангай, Өвөрхангай аймгийн нутаг дээгүүр урсах Орхон голын бургасанд 1994 оноос эхлэн цаашид улам ихсэх хандлагатай байна. Энэ эрвээхэй 6-р сарын сүүлч, 7-р сарын эхээр үй олноороо нисэж, нислэг 20-30 хоног үргэлжилнэ. Эрвээхэй өдрийн цагт бургасны навчны сүүдэр талд нуугдаж байгаад орой нар жаргахын өмнө нисэж эвцэлдээнд орно. Эмэгчин эрвээхэй бургасны мөчир, навч, иш, холтсон дээр өндгөө багц багцаар нь гаргадаг. Багцанд дунджаар 20-30 ш өндөг байх бөгөөд нэг эмэгчин 700 орчим өндөг гаргана.

Өндөгнөөс хүрэнцэрүүд гарч, 1-2 удаа гуужиж, хөгжсөний дараа газрын өнгөн хэсэгт орж ичдэг. Дараа жилийн хавар бургас нахиалах үеэр хүрэнцэр ичээнээсээ гарч ургаж буй бургасны навчаар хооллож ихээхэн гэмтлийг 30-35 хоногийн дотор учруулж хэд хэдэн удаа гуужин хөгжсөний дараагаар хүүхэлдэйн хөгжилдөө шилждэг. Хүрэнцэр бургасны мөчрийг мяндаслаг цагаан шүлсээр холбож торон гэр барьж түүн дотроо хүүхэлдэй болон хувирч 8-15 хоногийн дараагаар эрвээхэй болон нисэж эвцэлдээнд орно.

5-р схем

Бургасны бийрэн сүүлт эрвээхэйн хөгжлийн хуанли

5-р сар			6-р сар			7-р сар			8-р сар			9-р сар		
1	2	3	1	2	3	1	2	3	1	2	3	1	2	3
☉	☉	☉												
		-	-	-	-	-	-	-						
							+	+	+					
								++	++	++				
								≠	≠	≠				
		#	#	#	#	#	#	#						
		☪	☪	☪	☪	☪	☪	☪						
										☉	☉	☉	☉	☉

- ☐ - Өндөг
- + - Ганц нэгээрээ нисэх үе
- - Хүрэнцэр
- ++ - Үй олноороо нисэх үе
- ☐ - Хүүхэлдэй
- ☐ - Эвцэлдээнд орох
- # - Гоц аюул учруулдаг үе
- ☐ - Тэмцэх хугацаа

ХОЛТОСЧ ЦОХУУД

Холтосч цохын овог – Ipidae

Манай улсын ой бүхий нутагт 20-н төрөлд хамаарах 50 гаруй зүйл холтосч цох олноор байна. Тэдний дотроос *Stolytus morawitzi* Sem, *Blastophagus minor* Hart, *Blastophagus piniperda* L, *Dryocoetes baicalicus* Egg, *Trypodendron lineatum* 01, *Pityogenes baicalicus* Egg, *Lps acuminatus* Gyll, *Lps sexdentatus*, Boern, *Lps subelongatus* Motsch, *Orthotomicus suturalis* Gyll, *Orthotomicus proximus* Fichh, *Xyleborus dispar* F, *Xylechinus pilosus* Ratz, *Trypodendron niponicum* Blandf зэрэг зүйлийн цох Монгол Алтай, Хан Хөхий, Хөвсгөл, Хангай Хэнтийн уулархаг мужийн ойд нилээд их тархан багагүй хөнөөл учруулж байна.

Холтосч цохууд модыг доорх гурван үндсэн чиглэлээр гэмтээдэг. Бие гүйцсэн цох холтосыг нүхлэн орж анхны жим гаргадаг бөгөөд үүнийг “эх” цохын жим гэж нэрлэнэ. Энэ гаргасан жимдээ эх цохууд өндгөө гаргах бөгөөд өндөгнөөс авгалдай бий болонгуутаа холтосны золон, долонгоор хооллон олон салаа жим үүсгэж холтосыг гэмтээж эхэлнэ.

Авгалдайн энэ хооллолт модыг гэмтээх үндэс болно.

Цохууд нэмэлт идэш тэжээлийн хэмжээг ихээр хэрэглэсэний дараа үржлийн эрхтэнгүүд бүрэн боловсордог тул нахиа найлзуур, модлог эдийн зөөлөн хэсгийг идэж гэмтээж модыг их доройтуулна.

Эвцэлд орсон эмэгчин цохууд өндөглөж эхлэх боловч ахин нэмэлт тэжээл хэрэглэж байж үр төлөө гаргахын тулд шинэ модонд шилжиж холтосны золон, долон, зөөлөн эдээр хооллож модонд ихээр хөнөөл учруулна. Холтосч цохын зүйл тус бүрийн холтосонд болон модлогийн гадаргууд үүсгэсэн жим зам нь өвөрмөц хэлбэр дүрс бүтэцтэй байх тул уг хөнөөлт шавжийн зүйлийг таньж тодорхойлоход чухал үзүүлэлт болно.

ЭВЭРТ ЦОХУУД

Эвэрт цохын овог – Cerambycidae

Манай гариг дээр 17 мянган эвэрт цох тархан дэлгэрснээс Монгол оронд 140 гаруй зүйл тэмдэглэгдээд байгаагийн дотор 30 төрөлд хамаарах 58 зүйл нь ой модны хөнөөлт шавж гэж бүртгэгдээд байна.

Энэ овгийн цохын авгалдайнүүд төрөл бүрийн бут сөөг модонд техникийн гэмтэл учруулдагаараа ихэвчлэн модлог эдийн хоёрдогч хөнөөлт шавжийн төрөлд хамаарагдана. Энэ овгийн цохын бие гоолиг нарийхан, хавтайдуу болон бортого хэлбэртэй, сарвуу нь таван үетэй, их биенээсээ 1-1.5 дахин урт хойшоо чиглэсэн сахалтай 30-60 мм орчим биетэй байна. Авгалдайнүүд цагаан шаргал өнгөтэй, махлаг бүдүүн биетэй, толгой нь хар хүрэн өнгөтэй, ихэвчлэн

хөлгүй боловч зарим тохиолдолд цээжиндээ маш богино 3-н хос хөлтэй. Цээжний нэгдүгээр цагираг нь бусад хэсгээсээ бүдүүн байдаг зэргээрээ холтосон доор амьдрагч бусад шавжнуудаасаа амархан ялгагдана.

Эмэгчин цох өнгөө холтосны ан цав буюу холтосон дээр тусгайлан амаараа мэрж бэлтгэсэн хэрчилтэнд шахна. Ихэнх хөнөөлт эвэрт цохын авгалдайн бойжилтын эргэлтийн үе холтос, золон, долон, холтос дотор явагдана.

Эвэрт цохууд навчит, шилмүүст ойд техникийн гэмтэл учруулна. Нэлээд олон зүйлийн эвэрт цох, Сибирийн хүр, Өрөөсгөл хүр, Шинэсний шилмүүс хуйлагч, Эгэл бийрэн сүүлт зэрэг ой модны анхдагч хөнөөлт шавжинд нэрвэгдсэн хийгээд өвчин эмгэг, түймэрт нэрвэгдсэн, салхи шуурганд унасан, хугарсан, хэрэгцээнд бэлтгэж хураасан мод, мод бэлтгэлийн үлдэгдэл, хожууланд ихээр үрждэг.

Уг хөнөөлт шавж гантай жилүүдэд хуурайшиж байгаа модонд үржиж олшрохоос гадна тэдгээрийн тоо толгойн өсөлт, бууралтанд цаг уурын бусад хүчин зүйлийн үзүүлэлт онцгой нөлөө үзүүлнэ.

9.2. Ойн хөнөөлт шавжийн үнэмлэхүй нягтшилт

Бид судалгаа явуулсан газруудад шавжийн нягтшилтыг өндөг, хүрэнцэр, хүүхэлдэй, эрвээхэйн үе шатуудад хийсэн бөгөөд энд аж ахуйн ач холбогдлыг харгалзан үзээд хүрэнцэрийн нягтшилтыг тооцлоо.

Бидний судалгаа явуулсан газруудад ойн хөнөөлт шавж дараах нягтшилттай байсан \Хүснэгт 9\.

- Сибирийн хүр эрвээхэй хүрэнцэр нэг модонд 1 ± 1 ширхэг,
- Якобсоны төөлүүрч эрвээхэйн төөлүүрч нэг модонд 40 ± 10 ширхэг,
- Өрөөсгөл хүр эрвээхэйн хүрэнцэр нэг модонд 1 ± 1 ширхэг,
- Бургасны хүр эрвээхэйн хүрэнцэр нэг модонд 1 ± 1 ширхэг,
- Эгэл бийрэн сүүлт эрвээхэйн хүрэнцэр нэг модонд 1 ± 1 ширхэг,
- Шинэсний шилмүүс хуйлагч эрвээхэйн хүрэнцэр нэг мод дээр 1 ± 1 ширхэг тус тус тоологдсон.

Хүснэгт 9

Ойн хөнөөлт шавжийн үнэмлэхүй нягтшилт

Д/д	Зүйлийн нэр	Аймгийн нэр	Голомттой талбай, га	Үнэмлэхүй нягтшил		Pr p	Харьцангуй нягтшилт		K _L
				2017	2018		2016	2017	
1	Сибирийн хүр эрвээхэй	Баянхонгор	-	-	1±1 ширхэг/мод				
	Шинэсний шилмүүс хуйлагч	Говь-Алтай	-	-	1±1 ширхэг/мод				
	Эгэл бийрэн сүүлт эрвээхэй	Говь-Алтай	-	-	1±1 ширхэг/мод				
	Якобсоны төөлүүрч эрвээхэй	Баянхонгор	-	-	1±1 ширхэг/мод				
		Говь-Алтай	-	-	40±10 ширхэг/мод				
	Бургасны хүр эрвээхэй	Баян Өлгий	-	-	1±1 ширхэг/мод				
ДҮН			-						

Ойн хөнөөлт шавжийн хамгийн өндөр үнэмлэхүй нягтшилт



Зураг № 20

9.2. Ойн хөнөөлт шавжийн тархалт, голомт

Судалгаанд хамрагдсан нийт 400,000.0 га талбайн 2.4 хувь буюу 9,494.0 га талбайд ойн хөнөөлт шавж тархсан, 0.5 хувь буюу 2,194.0 га талбайд ойн хөнөөлт шавжийн голомт илэрсэн байна \Хүснэгт 10-19\.

Судалгаа явуулсан газруудад Эгэл бийрэн сүүлт, Якобсоны төөлүүрч эрвээхэй тархаж, Якобсоны төөлүүрч эрвээхэй бага хэмжээний талбайд голомт үүсгэсэн байна \Хүснэгт 10-19\.

Эндээс харахад тухайн судалгаа явуулсан газруудад ойн хөнөөлт шавжийн хөнөөл харьцангуй бага байгааг харуулж байна.

Хүснэгт 10

Ойн хөнөөлт шавжийн тархалт, га /шавжийн зүйлүүдээр/

№	Аймгийн нэр	Судалгаанд хамрагдсан сумдын тоо	Судалгаанд хамрагдсан талбай /га/			Шавжийн зүйлийн нэр
			Нийт	Тархалттай	Голомттой	
1	Баян-Өлгий аймаг	7 сум	77,064.0	-	-	-
2	Баянхонгор аймаг	7 сум	220,600.0	5300	-	Эгэл бийрэн сүүлт, Сибирийн хүр эрвээхэй
3	Ховд аймаг	6 сум	41,736.0	-	-	-
4	Говь-Алтай	5 сум	60,600.0	4194	2,194.0	Эгэл бийрэн сүүлт эрвээрхэй
НИЙТ			400,000.0	9,494.0	2,194.0	-

Хүснэгт 11

Ойн хөнөөлт шавжийн тархалт, голомт, га

Д/д	Ойн хөнөөлт шавжийн зүйлийн нэр	Судалгаанд хамрагдсан аймаг	Талбайн хэмжээ, га
Ойн хөнөөлт шавжийн тархалт			
1	Эгэл бийрэн сүүлт эрвээхэй	Говь-Алтай	1,500.0
2		Баянхонгор	5,300.0
3	Якобсоны төөлүүрч эрвээхэй	Говь-Алтай	2,694.0
4			
	ДҮН		9,494.0
Ойн хөнөөлт шавжийн голомт			
5	Якобсоны төөлүүрч эрвээхэй	Говь-Алтай	2,194.0

ДҮН	2,194.0
------------	----------------

Хүснэгт 12

Баянхонгор аймгийн ойн хөнөөлт шавжийн тархалттай талбай, га

№	Сумын нэр	Судалгааны ажил явуулах төлөвлөгөө /га/	Судалгаанд хамрагдсан талбай, га	Тархалттай талбайн хэмжээ, га	Голомттой талбайн хэмжээ, га	Ойн хөнөөлт шавжийн зүйлийн нэр
1	Баянлиг	60,000.0	60,000.0	-	-	-
2	Баяновоо	600	600	-	-	-
3	Галуут	40000	40000	2100	-	-
4	Жаргалант	9000	9000	-	-	-
5	Өлзийт	1000	1000	-	-	-
6	Эрдэнэцогт	40000	40000	3200	-	-
7	Баян Өндөр	70000	70000	-	-	-
НИЙТ ДҮН		220,600.0	220,600.0	5300	-	-

Хүснэгт 13

Баян-Өлгий аймгийн ойн хөнөөлт шавжийн тархалттай талбай, га

№	Сумын нэр	Судалгааны ажил явуулах төлөвлөгөө /га/	Судалгаанд хамрагдсан талбай, га	Тархалттай талбайн хэмжээ, га	Голомттой талбайн хэмжээ, га	Ойн хөнөөлт шавжийн зүйлийн нэр
1	Алтай	2600	2600	-	-	-
2	Алтанцөгц	12000	12000	-	-	-
3	Баяннуур	12000	12000	-	-	-
4	Бугат	1200	1200	-	-	-
5	Булган	30000	30000	-	-	-
6	Дэлүүн	1000	1000	-	-	-
7	Ногооннуур сум	18264	18264	-	-	-
НИЙТ ДҮН		77,064.0	77,064.0	-	-	-

Хүснэгт 14

Говь Алтай аймгийн ойн хөнөөлт шавжийн тархалттай талбай, га

№	Сумын нэр	Судалгааны ажил явуулах төлөвлөгөө /га/	Судалгаанд хамрагдсан талбай, га	Тархалттай талбайн хэмжээ, га	Голомттой талбайн хэмжээ, га	Ойн хөнөөлт шавжийн зүйлийн нэр
1	Жаргалан	17420	17420	1500	-	-
2	Халиун	6376	6376	1100	600	-
3	Есөнбулаг	16040	16040	1594	1594	-
4	Шарга	1396	1396	-	-	-
5	Тайшир	504	504	-	-	-

НИЙТ ДҮН	41,736.0	41,736.0	4,194.0	2,194.0	-
-----------------	-----------------	-----------------	----------------	----------------	---

Хүснэгт 15

Ховд аймгийн ойн хөнөөлт шавжийн тархалттай талбай, га

№	Сумын нэр	Судалгааны ажил явуулах төлөвлөгөө /га/	Судалгаанд хамрагдсан талбай, га	Тархалттай талбайн хэмжээ, га	Голомттой талбайн хэмжээ, га	Ойн хөнөөлт шавжийн зүйлийн нэр
1	Алтай	18200	18200	-	-	-
2	Булган	30000	30000	-	-	-
3	Дарви	1400	1400	-	-	-
4	Мянгад	4800	4800	-	-	-
5	Үенч	1800	1800	-	-	-
6	Эрдэнэбүрэн	4400	4400	-	-	-
НИЙТ ДҮН		60,600.0	60,600.0	-	-	-

Хүснэгт 16

Баянхонгор аймгийн ойн хөнөөлт шавжийн тархалттай талбайн
хэсэглэлийн дугаар

№	Сумын нэр	Судалгаанд хамрагдсан талбай, га	Ойн хөнөөлт шавжийн тархалттай		Ойн хөнөөлт шавжийн голомттой		Ойн хөнөөлт шавжийн зүйлийн нэр
			Талбайн хэмжээ, га	Хэсэглэлийн дугаар	Талбайн хэмжээ, га	Хэсэглэлийн дугаар	
1	Баянлиг	60,000.0	-	-	-	-	-
2	Баяновоо	600	-	-	-	-	-
3	Галуут	40000	2100	10-16, 42, 44, 45	-	-	Эгэл бийрэн сүүлт
4	Жаргалант	9000	-	-	-	-	-
5	Өлзийт	1000	-	-	-	-	-
6	Эрдэнэцогт	40000	3200	52-54, 34, 37, 47, 48	-	-	Эгэл бийрэн сүүлт
7	Баян Өндөр	70000					
НИЙТ		220,600.0	5300	-	-	-	-

Хүснэгт 17

Говь-Алтай аймгийн ойн хөнөөлт шавжийн тархалттай талбайн хэсэглэлийн дугаар

№	Сумын нэр	Судалгаанд хамрагдсан талбай, га	Ойн хөнөөлт шавжийн тархалттай		Ойн хөнөөлт шавжийн голомттой		Ойн хөнөөлт шавжийн зүйлийн нэр
			Талбайн хэмжээ, га	Хэсэглэлийн дугаар	Талбайн хэмжээ, га	Хэсэглэлийн дугаар	
1	Жаргалан	17420	1500	-	-	-	Эгэл бийрэн сүүлт
2	Халиун	9228	1100	1-11	600	1,2,3,4	Якобсоны төөлүүрч эрвээхэй
3	Есөнбулаг	3188	1594	1-6	1594	1-6	Якобсоны төөлүүрч эрвээхэй
4	Шарга	11396	-	-	-	-	-
5	Тайшир	504	-	-	-	-	-
НИЙТ		41,736.0	4194.0	-	2194.0	-	-

Хүснэгт 18

Ойн хөнөөлт шавжийн тархалт – шавжийн зүйлээр

№	Аймгийн нэр	Сибирийн хүр эрвээхэй	Бургасны бийрэн сүүлт эрвээхэй	Өрөөсгөл хүр эрвээхэй	Якобсоны төөлүүрч эрвээхэй	Эгэл бийрэн сүүлт эрвээхэй	Бургасны хүр эрвээхэй	Шилмүүс хуйлагч	НИЙТ
1	Ховд	-	-	-	-	-	-	-	-
2	Баян-Өлгий	-	-	-	-	-	-	-	-
3	Баянхонгор	-	-	-	-	5300	-	-	5300
4	Говь-Алтай	-	-	-	2694	1500	-	-	4194
НИЙТ ДҮН		-	-	-	2694	6800	-	-	9494

Хүснэгт 19

Ойн хөнөөлт шавжийн голомт – шавжийн зүйлээр

№	Аймгийн нэр	Сибирийн хүр эрвээхэй	Бургасны бийрэн сүүлт эрвээхэй	Өрөөсгөл хүр эрвээхэй	Якобсоны төөлүүрч эрвээхэй	Эгэл бийрэн сүүлт эрвээхэй	Бургасны хүр эрвээхэй	Шилмүүс хуйлагч	НИЙТ
1	Ховд	-	-	-	-	-	-	-	-
2	Баян-Өлгий	-	-	-	-	-	-	-	-
3	Баянхонгор	-	-	-	-	-	-	-	-
4	Говь-Алтай	-	-	-	2194	-	-	-	2194
НИЙТ ДҮН		-	-	-	2194	-	-	-	2194

9.4. Тэмцлийн ажлын үр дагаврын мониторинг судалгааны дүн

Тэмцлийн ажлын дараах мониторинг судалгааг бид тэмцлийн ажлын техникийн үр дүнг тооцох, тэмцлийн ажлын дараах сөрөг үр дагаврыг тооцох зохилгоор гүйцэтгэдэг.

Судалгаа явуулсан газар нутгуудад тэмцлийн ажил хийгдээгүй тул тэмцлийн ажлын үр дүнг, үр дагаврыг тооцох судалгааны ажил хийгдээгүй болно.

9.6. Ойн хөнөөлт шавжтай 2019, 2020 онд тэмцэл явуулах талбайн хэмжээ

Бидний судалгаа явуулсан газар нутгуудад өмнөх жилүүдэд ойн хөнөөлт шавжийн голомттой талбай илрээгүй тул 2019 онд тэмцэл явуулах талбай сонгож тусгаарлаагүй болно.

Харин энэ жилийн хувьд Говь-Алтай аймгийн Халиун Есөн булаг зэрэг сумын нутаг Якобсоны төөлүүрч эрвээхэй 2194 га талбайд голомт үүсгэсэн байсан бөгөөд голомттой талбайд нэлэнхүйд нь тэмцэл явуулах шаардлагатай байсан /Хүснэгт 20/.

Иймд Говь-Алтай аймгийн Халиун суманд 600 га талбайд, Есөнбулаг суманд 1594 га талбайд нийт 2194 га талбайд 2020 онд улсын төсвийн хөрөнгөөр тэмцлийн ажил явуулах шаардлагатай байна /Хүснэгт 20/.

Тэмцэл явуулах талбай нь налуугийн хэмжээ их, өндөрлөг газарт байрлах тул тэмцлийн ажлыг агаараас онгоцоор авиамикробиологийн аргаар гүйцэтгэх шаардлагатай байна.

Хүснэгт 20

2020 онд Говь-Алтай аймагт тэмцэл явуулах шаардлагатай газар нутаг, талбайн хэмжээ

Д/д	Сумын нэр	Хэсэглэлийн дугаар	Талбайн хэмжээ	Тэмцэх арга	Төрөл, зүйл
1	Есөнбулаг	1,2,3,4,5,6	1594	Авиамикробиологийн аргаар	Якобсоны төөлүүрч эрвээхэй
	ДҮН		1,594.0		
2	Халиун	1,2,3,4	600	Авиамикробиологийн аргаар	Якобсоны төөлүүрч эрвээхэй
	ДҮН		600.0		
	ДҮН	-	2,194.0	-	

Дүгнэлт, санал

1. Судалгаанд хамрагдсан нийт 400,000.0 га талбайн 2.4 хувь буюу 9,494.0 га талбайд ойн хөнөөлт шавж тархсан, 0.5 хувь буюу 2,194.0 га байна. Энэ нь тухайн судалгаа явуулсан газруудад ойн хөнөөлт шавжийн хөнөөл харьцангуй бага байгааг харуулж байгаа хэдий өнгөрсөн жилийнхтэй харьцуулахад шинээр хөнөөлт шавжийн голом илэрсэн байгааг анхаарч цаашид судалгааг тогтмол нарийвчлан явуулах шаардлагатай байна.
2. Судалгаа явуулсан газруудад Хайрсан далавчтан \Lepidoptera\ -ы багийн Хүр эрвээхэйн овог \Lasiocampidae\ -ийн овгийн 1 зүйл \Denrolimus sibiricus Tschetw\, Бийр сүүлтийн овог \Orgyidae\ -ийн 3 зүйл \Lymantria dispar Linn, Orgyia antique Linn, Stilpnotia salicis Linn\, Навч хуйлагчийн овог \Tortricidae\ -ийн 1 зүйл \Zeiraphera diniana Gn\, Төөлүүрийн овог \Geometridae\ -ийн 1 зүйл \Erannis jacobsoni Diak\ тохиолдож, үүнээс эгэл бийрэн сүүлт эрвээхэй Orgyia antique Linn тархаж байна.
3. Бидний судалгаа явуулсан газар нутгуудад 2194 га талбайд яacobсоны төөлүүрч эрвээхэйн голомт илэрсэн бөгөөд голомттой нийт талбайд тэмцлийн ажлыг явуулах шаардлагатай байна.
4. Тэмцэл явуулах талбай нь налуугийн хэмжээ их, өндөрлөг газарт байрлах тул тэмцлийн ажлыг агаараас онгоцоор авиамикробиологийн аргаар гүйцэтгэх шаардлагатай болно.
5. Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх арга хэмжээний төлөвлөгөө, бодлого боловсруулах, урт болон богино хугацааны прогноз гаргахын тулд ойн хөнөөлт шавжийн тархалтын судалгааны ажлыг жил бүр 2 давталттайгаар /хавар, намар/ тогтмол явуулах шаардлагатай байна.
6. Ойн нөхөрлөл, ард иргэд, ой ангийн мэргэжилтэн, БОХ-ын улсын байцаагч, байгаль хамгаалагч нарт ойн хөнөөлт шавжийн хор хөнөөл, тоймчилсон судалгаа явуулах талаар сургалт явуулах шаардлагатай байна.

Ашигласан материал

1. Байгаль орчны төлөв байдлын тайлан \2006, 2008 он\,
2. Байгаль орчин ногоон хөгжлийн яамны –ны веб сайт,
3. Намхайдорж.Б, Дорж.И, Гэрэл.Б “ Монгол улсын ойн зонхилох хөнөөлт эрвээхэйг бойжилтын үе шат, нас хүйсээр ялган таних, тэдгээртэй тэмцэх арга ажиллагааны үндэс ” 2006 он, Улаанбаатар хот,
4. Намхайдорж.Б, Монголын өндөрлөгийн эвэрт цохын атлас,
5. Жанцантомбоо.Х, “Монгол орны ойн гол хөнөөлт шавж”, 2003 он,
6. ОУХСТ-ийн тайлан, 2005, 2006, 2007, 2008 он,
7. William J. Sutherland, Ecological Census Techniques, Hand book, 1996
8. WS Abbott - J. econ. Entomol, 1925 - bcin.ca, PRUESS, KENNETH P., [Environmental Entomology](#), Volume 12, Number 3, June 1983 , pp. 613-619(7)/
9. HYSLOP, J. A. [Journal of Economic Entomology](#), Volume 17, Number 2, April 1924 , pp. 177-180(4)/.